

# **ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ**

Сургагч багшийн гарын авлага

Улаанбаатар хот  
2009 он

Зөвлөх:

1. Д.Зүмбэрэлхам - Хуульзүйн Үндэсний Төвийн Криминологийн судалгааны секторын эрхлэгч, хууль зүйн ухааны доктор, профессор
2. Н.Гантулга - Цагдаагийн Академийн сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн тэргүүн дэд захирал, цагдаагийн хурандаа, хууль зүйн ухааны доктор, дэд профессор
3. Я.Пүрэвдорж - Хилийн Цэргийн Дээд Сургуулийн дэд захирал, доктор, профессор, Хошууч генерал
4. Г.Гантөмөр - Цагдаагийн Академийн Эрүүгийн эрх зүй, криминологийн тэнхимиийн эрхлэгч, цагдаагийн хурандаа, хууль зүйн ухааны доктор, дэд профессор

Ерөнхий редактор:

Б.Батзориг - Авлигатай тэмцэх газрын судалгаа шинжилгээний албаны дарга, Ахлах комисsar

Боловсруулсан:

1. Б.Батзориг - Авлигатай тэмцэх газрын судалгаа шинжилгээний албаны дарга, Ахлах комисsar
2. Н.Баясгаланбат-Цагдаагийн Академийн ЭБШЭЗ ба Криминиластикийн тэнхимиийн ахлах багш, цагдаагийн ахмад
3. С.Гантулга - Цагдаагийн Академийн Төр, захиргааны эрх зүйн тэнхимиийн багш, цагдаагийн дэслэгч
4. С.Ичинхорлоо - Хил хамгаалах ерөнхий газрын мэдээлэл дүн шинжилгээний хэлтэсийн ахлах мэргжилтэн, дэд хурандаа
5. Г. Лхагвамаа - Хилийн Цэргийн Дээд Сургуулийн Эрх зүйн тэнхимиийн эрхлэгч, ахлах дэслэгч

## ӨМНӨХ ҮГ

Хүн нь өөртэйгээ ижил заяанд төрсөн бусдыгаа мал адгуус, эд бараатай адил наймаалан худалдаж тэднийг төрөл бүрийн хэрэгцээндээ өмчийн журмаар хэрэглэж, ашигладаг байсан боолын нийгэм улирсаар басхүү чамгүй хугацааг үдэж, хүний заяагдмал эрхийг дэлхий даяар хүлээн зөвшөөрсөн ухаалааг, энэрэнгүй ёсыг дээдэлдэг цаг үетэй хүн төрөлхтөн золгосноор хүний эрх, эрх чөлөөг хүндлэх, түүнийг хамгаалан хэрэгжүүлэхэд нийгмийн хамгийн таатай нөхцлийг бүрдүүлэх явдал өнөөгийн ертөнцийн гол зорилгод тооцогдох болов.

Хэдийгээр дэлхийн улс орнуудын улс төр, нийгмийн бодлогод ийм урин цаг ирсэн боловч сүүлийн жилүүдэд хүний наймаа түүхэнд үлдсэн өнгө төрхөө өөрчилен газар авч хар тамхи, зэвсгийн наймааны нэгэн адил өндөр ашиг олдог хууль бус нууц орлогын эх сурвалж болж, энэ үйл ажиллагааг эрхэлдэг бүлэглэлүүдийн зохион байгуулалтын сүлжээ олон улсыг хамарч улам өргөжин тэлэх боллоо. Энэ үзэгдэл хүний нэр төр, аюулгүй байдалд онц ноцтой аюул учруулж, дэлхийг түгшээх хэмжээнд хүрснийг НҮБ болон олон улс, бус нутгийн байгууллагууд хүлээн зөвшөөрч түүнтэй тэмцэх талаар хэд хэдэн чухал баримт батлан гаргаад байгаа бөгөөд энэ нь улс орнууд хүний наймаатай хамтран тэмцэх эрх зүйн эх сурвалж болж байна.

Манай улс хүний наймааны эсрэг олон улсын гэрээнүүдэд нэгдэн орж, тухайн үзэгдлийн эсрэг тууштай тэмцэх үүргийг дэлхийн хамтын нийгэмлэгийн өмнө хүлээсэн нь хүний наймаанд өртөх өндөр эрсдэлтэй орны тоонд багтаж байгаа улсын хувьд энэ талаар эрчимтэй арга хэмжээ авч урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох ажлыг үр нөлөөтэй явуулах бодлого баримталж байгаагийн илэрхийллэл юм.

Хүний наймаатай үр дүнтэй тэмцэл явуулахад нэн тэргүүнд энэ талаар үүрэг хүлээсэн төрийн албан хаагчидад уг үзэгдлийн мөн чанар, хор уршгийг сайтар ойлгуулж, тэмцэх арга зүйг эзэмшигжүүлэн, ур чадварыг дээшлүүлэх явдалд анхаарах ёстой. Үүнийг шийдвэрлэхэд шинжлэх ухааны үндэстэй сургалт явуулж тухайн төрлийн гэмт хэргийн шалтгаан нөхцлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах, таслан зогсоох тухай гэмт явдал судлалын мэдлэг, тус гэмт хэргийг нотлох, шүүн таслах талаар Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн мэдлэг, энэ төрлийн гэмт хэргийн мөрдөн байцаалтын тактик, арга зүйн мэдлэг, гэмт этгээдүүд болон хохирогч, гэрч зэрэг байцаан шийтгэх ажиллагааны оролцогчидтой харилцах сэтгэл зүйн онцлогийн талаарх мэдлэг зэрэг олон талын иж бүрэн мэдлэгийг албан хаагчидад олгож, мэргэшүүлэн сургах шаардлагатай.

Хүний наймааны гэмт хэрэгтэй тэмцэх нь төрийн үүрэг мөн боловч энэ үүргээ олон нийтийн дэмжлэг, иргэний нийгмийн идэвхтэй оролцоогүйгээр биелүүлэх боломж муутай. Ийм үед НҮБ-ийн Хүүхдийн сан, Монголын Хүйсийн Тэгш Эрхийн Төвөөс хүн худалдаалах гэмт явдалтай тэмцэх талаар Цагдаагийн Академи, Хилийн Цэргийн Дээд Сургуулийн сургалтын хөтөлбөрт бие даасан хичээл оруулах асуудлыг санаачлан энэхүү сургалтын гарын авлагыг мэргэжлийн эрдэмтэд судлаачдын тусlamжтайгаар ийнхүү бэлтгэсэн нь сайшаалтай. Агуулга, багтаамжийн хувьд энэхүү гарын авлага сургалтын зорилгыг биелүүлэхэд хангалттай гэж үзэж байна.

Цаашид ийм сургалтыг төрийн тусгай албаны дээрх сургуулиудаас гадна хуулийн мэргэжлийн бусад сургуулиуд, мөн тухайн гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг бүхий төрийн албан хаагчидад явуулах нь чухал юм.

Зөвлөх Д.Зүмбэрэлхам

Хуульзүйн Үндэсний Төвийн Криминологийн  
судалгааны секторын эрхлэгч, хууль зүйн  
ухааны доктор, профессор

## **АГУУЛГА**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: Хүн худалдаалах гэмт хэргийн тухай ойлголт, түүнтэй хийх олон улсын тэмцэл, криминологийн зарим асуудал**

- 1.1 Хүний наймааны түүх
- 1.2 Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын жишиг
- 1.3 Хүүхдийн эрхийн конвенци, нэмэлт протоколын агуулга мөн чанар
- 1.4 Хүн худалдаалах гэмт хэргийн онцлог
- 1.5 Хүн худалдаалах гэмт хэргийн криминологи шинж

**ХОЁРДУГААР БҮЛЭГ: Хүн худалдаалах гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн шинж**

- 2.1. Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж
  - 2.1.1. Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний объект
  - 2.1.2. Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив тал
  - 2.1.3. Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний субъект
  - 2.1.4. Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив тал
- 2.2. Хүн худалдаалах гэмт хэргийн хүндрүүлэх болон онцлон хүндрүүлэх бүрэлдэхүүн
- 2.3. Хүн худалдаалах гэмт хэргийг төсөөтэй гэмт хэргээс ялган зүйлчлэх нь
- 2.4. Хүн худалдаалах гэмт хэргийг гадаад орнуудын Эрүүгийн хууль тогтоомжуудад хуульчилсан байдлыг харьцуулан судлах нь

**ГУРАВДУГААР БҮЛЭГ: Хүн худалдаалах гэмт хэргийг нотлох ажиллагаа**

- 3.1. Хүн худалдаалах гэмт хэргийн нотлох баримт ба нотлогдвол зохих байдлуудын харилцан хамаарал
  - 3.1.1 Хүн худалдаалах гэмт хэргийн нотлох баримт, төрөл
  - 3.1.2 Хүн худалдаалах гэмт хэрэгт нотлогдвол зохих байдлууд, хэмжээ хязгаар
- 3.2. Эрүүгийн хэрэг үүсгэх үе шатанд хүн худалдаалах гэмт хэргийн шинж тэмдгийг тогтоох ажиллагаа, онцлог
  - 3.2.1 Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч, шалгах ажиллагаа, анхаарвал зохих асуудлууд

- 3.2.2 Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шийдвэрлэх ажиллагаа, тогтоогдвол зохих нөхцөл байдлууд
- 3.3 Мөрдөн байцаалтын үе шатанд хүн худалдаалах гэмт хэргийг нотлох ажиллагаа, онцлог
- 3.3.1 Хүн худалдаалах гэмт хэргийг нотлох ажиллагааны мөн чанар, үе шат
- 3.3.2 Эрүүгийн байцаан шийтгэх тодорхой ажиллагааны явцад хүн худалдаалах гэмт хэргийн нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх ажиллагаа, онцлог
- 3.4 Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа

***ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ТАЛААР ЦАГДАА,***

**ХИЛИЙН ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧ, ЦАГДААГИЙН АКАДЕМИ,  
ХЦДС-ИЙН СОНСОГЧ НАРТ СУРГАЛТ ЯВУУЛАХАД  
АНХААРАХ ЗҮЙЛС**

Цагдаа, хилийн цэргийн албан хаагч, Цагдаагийн Академи, Хилийн цэргийн дээд сургуулийн сонсогч нарт сургалт явуулахад иргэд болон энгийн сургуулийн оюутнуудад явуулахаас нилээд ялгаатай байдаг. Энэ нь мэргэжлийн нарийн гярхай, өөнтөгч байдал, насанд хүрэгчдийн хатуу тогтсон хандлага, байр суурь зэргээр илэрдэг.

Иймд сургагч багшийн зүгээс хүн худалдаалах гэмт хэргийн тухай ойлголт, гэмт хэргийн бүрэлдэхүүний үндсэн шинж, энэ төрлийн гэмт хэргийг төсөөтэй гэмт хэргүүд ялан зүйлчлэх, хүн худалдаалах гэмт хэргийг гадаад орнуудын Эрүүгийн хууль тогтоомжуудад хуульчилсан байдал, энэ төрлийн гэмт хэрэгтэй олон улсын болон үндэсний хэмжээнд тэмцэж буй байдал, хүн худалдаалах гэмт хэргийг нотлох ажиллагаа, нотлох ажиллагааны онцлог зэргийг сайтар судалж, хүн худалдаалах гэмт хэргийн талаар төгс мэдлэг эзэмшсэн байхын зэрэгцээ сурган заах арга зүйн болон бусдыг өөртөө татах, тайлбарлан таниулах зэрэг ур чадвар эзэмшсэн байхыг шаарддаг.

Сургалтыг сайтар зохион байгуулж, хүн худалдаалах гэмт хэргийн талаар сонсогч, оюутнууд болон цагдаа, хилийн цэргийн алба хаагчдад ойлгуулахын тулд нэн тэргүүнд сэдвийн дагуу төлөвлөгөө гарган, түүнд тусгагдсан зүйлсийг цаг тухай бүр нь бүрэн гүйцэтгэж ажиллах нь зүйтэй юм. Үүнд:

- Сэдвийн агуулгаас шалтгаалан хугацааг тооцох;
- Сэдвүүдийн дэс дараалал, хоорондын холбоо хамаарлыг тооцох;
- Сургалтанд оролцогчдын хувийн байдал, эрхэлж буй албан тушаал, цол зэргээс нь хамаарч бүлэглэж болох эсэхийг тогтоох;
- Сургалтын хэлбэр, ашиглах аргаа сонгож, сургалтанд хэрэглэгдэх техник хэрэгсэл, хэрэглэгдэхүүнийг урьдчилан бэлтгэх;
- Хялбарчлах, ойлгомж, идэвхийг нэмэгдүүлэх жишээ баримтыг цуглуулах зэргийг төлөвлөгөөндөө тусгах;

Сургалт ярилцлагыг явуулахын өмнө сургагч багш нь сургалтад хамрагдагсдынхаа онцлогыг мэдэж байхаас гадна сургалтын гол зорилго, агуулгыг сайтар ойлгох, мөн ойлгуулан таниулах чадварыг эзэмшсэн байх, хүн худалдаалах гэмт хэргийн талаарх холбогдох ном сурх бичиг, гарын авлага зэргийг уншиж судалсан байвал зохино.

**Цагдаа, хилийн цэргийн албан хаагч нарт сургалт явуулахад анхаарах зүйлс**

- Цагдаа, хилийн цэргийн алба хаагч нар аливаа асуудалд хандахдаа сөрөг талд илүү анхаарал хандуулж, ярьж буй зүйлийг тань өөлөх, дахин лавлах байдал гардаг. Тиймээс аль болох эргэлзээтэй зүйл ярихгүй, баттай эх сурвалжид тулгуурлан сургалтыг явуулах шаардлагатай.

- Сургалтад хамрагдаж буй хүмүүсийн оролцоог тэнцвэртэй байлгах, сургалтыг үр өгөөжтэй, сонирхолтой явуулахын тулд баг бүлгээр ажиллуулахдаа тэдний албан тушаал, цол, гүйцэтгэх ажил үүргийн онцлогийг харгалзан хуваарилах нь зүйтэй.
- Цагдаа, хилийн цэргийн байгууллага нь шат дараалсан удирдлагатай. Иймээс та сургалтанд хамрагдасдын эрхэлж буй албан тушаал, цол, зэрэг дэвийн ялгаатай байдлыг харгалзан үзэх нь зүйтэй. Энэ нь та тэдний удирдлагын дэмжлэгийг авч чадвал цагдаа, хилийн цэргийн алба алба хаагчдыг удирдахад чухал ач холбогдолтой гэсэн үг юм. Үүний тулд та өөрсдийн үйл ажиллагаа, сургалтын онцлог, үр дүнгийн давуу болон сул талыг нь орхигдуулалгүй сайтар танилцуулах хэрэгтэй.
- Онолын тулгуур ойлголтуудыг заахдаа төрөл бүрийн практик жишээгээр баяжуулан, холбогдох хууль, хууль тогтоомжийн үзэл баримтлал, хуульд орсон ээдрээтэй, хоёрдмол утгатай ойлголт, нэр томъёо, шүүхийн практик, тухайн сэдвийг гүнзгийрүүлэн судлахад ашиглах материалыг суралцагсдад зааж тайлбарлаж өгөх шаардлагатай юм.
- Эхний хичээл дээрээс л тэдний харилцаа хандлага харагдана. Ихэнхдээ үл тоосон шинжтэй, ярьсан юмыг мушгих хандлага илрэх магадлал өндөр байдаг. Гэхдээ та үүнд бууж өгөх хэрэггүй бөгөөд энэ байдлыг эхний үед л арилгах арга хэмжээг авах хэрэгтэй. Энэ нь таны мэдлэг, өөртөө итгэлтэй байдал болон бусдыг итгүүлэн үнэмшүүлэх чадвараас хамаарна. Та ингэж чадвал хичээлээ үргэлжлүүлэн заахдаа санаа зоволтгүй болно.
- Цагдаа, хилийн цэргийн алба хаагчдын хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх ажил үүргээ гүйцэтгэхэд тулгамдаж буй асуудал, түүнийг даван туулах арга замын талаар харилцан ярилцах, тэдний үзэл бодлыг сонсох нь сургалтын үр дүнтэй шууд хамааралтай бөгөөд мөн сургагч багшийн хүн худалдаалах гэмт хэргийн талаарх мэдлэг, мэдээлэл ч өргөжих талтай.

#### **Цагдаагийн Академи, Хилийн цэргийн дээд сургуулийн сонсогч наарт сургалт явуулахад анхаарах зүйлс**

- Сонсогч наарт шинэ мэдээллийг өгөхдөө хэт сунжирсан бус товчхон, холбогдох хууль, хууль тогтоомжийн зүйл заалттай нь холбон, амьдралд ойрхон тодорхой жишээгээр баяжуулан, харилцан ярилцлага хийх, баг бүлгээр ажиллуулах, дүрд тоглуулах, өртөөчлөх, байр сууриа хамгаалах зэрэг сургалтын аргыг ашиглан явуулбал илүү үр дүнтэй.
- Сургагч багш та сонсогчдын дунд чөлөөтэй, нээлттэй харилцаатай байх тусам тэд ч мөн тантай биеэ барилгүй илэн далангүй харилцаж, үзэл бодлоо чөлөөтэй хуваалцах болно. Энэ нь мэдээллийг чөлөөтэй солилцох боломжийг нэмэгдүүлж сургалтыг илүү үр дүнтэй болгодог. Гэхдээ хичээлийн сэдвээс хазайхгүйгээр сэдвийн хүрээнд чөлөөт ярилцлага явуулж байх хэрэгтэй.
- Дараагийн сэдвийг заахдаа сэдэв хоорондын уялдаа холбоо, харилцан

хамаарал зэргийг сайтар тайлбарлан өгч, өмнө үзсэн сэдвийг сэргээн сануулах зорилгоор багахан хугацаанд ярилцах, сэдэвт хамаарал бүхий зарим нэр томъёонуудын талаар сонсогчдоос асуух, тэдэнд тайлбарлан өгөх нь ач холбогдолтой.

- Цагдаагийн Академийн зарим сонсогч нар цагдаагийн байгууллагад 1-7 хүртэлх жилийн хугацаатайгаар ажиллаж байгаад тус сургуульд элсэн суралцсан, мөн эчнээ хэлбэрээр суралцаж буй цагдаагийн алба хаагч нар байдаг тул тэдэнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг илтэд буруушаасан, зааж зааварласан байр сууринаас хандахад тааламжтай бус байдаг. Учир нь тэд тодорхой хэмжээний мэдлэг туршлагыг хуримтлуулсан байдаг. Бусад салбарынхан ч мөн үүнтэй төстэй гэдгийг анхаарах ёстой.

### *Сургагч багшийн зүгээс анхаарах зүйлс*

Та өөрийгөө оюун ухаан, мэдлэг чадварын хувьд бусдаас дутуугүй, тухайн сэдвээр илүү бэлтгэлтэй байгаа гэдгээ илэрхийлж, үүнийгээ ярианы далимд ойлгуулж чадвал таныг сурагцагсад илүү хүндэтгэх болно. Учир нь хэн ч өөрөөсөө дор мэдлэгтэй юмуу эсвэл ярьж байгаа зүйлээ өөрөө ч сайн мэдэхгүй хүнээр хичээл заалгаад байх сонирхолгүй байдаг.

Цагдаа, хилийн цэргийн албан хаагч, Цагдаагийн Академи, Хилийн цэргийн дээд сургуулийн сонсогч нарт хичээл заах багш нь Либерал Эмэгтэйчүүдийн Оюуны сангаас эрхлэн гаргасан “Хүний эрхийг заах нь” гарын авлагаас хүн худалдаалах гэмт хэргийн талаарх сургалтанд ашиглаж болох аргачлалуудыг, Эмнести Интернешнл байгууллагаас эрхлэн гаргасан “Хүний эрх ба хууль сахиулах нь” сургагч багш нарт зориулсан гарын авлагаас сургалт ярилцлага, оролцооны аргын талаар, Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн “Бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх нь” гарын авлагаас сургалтанд суралцагсдыг бүтээлчээр идэвхтэй оролцуулах арга, аргачлалын талаар тус тус үзэж судалсан байх шаардлагатай.

Сургалтыг зохион байгуулах эдгээр ерөнхий зүйлсээс гадна сургалтын явцад багш оролцогчдын харилцаанд дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй. Та өөрийн болон бусдын зарим нэг тодорхой зан үйлийг мэдэрч сургалтын үед хянаж, удирдан зохицуулж байх нь сургалтыг үр дүнтэй болгоход чухал нөлөөтэй.

- Сургалтад оролцож буй хүмүүсийн уур амьсгал, нөлөөлөлд автахгүй байхыг хичээ. Ингэхийн тулд та идэвхитэй дайчин байх хэрэгтэй.
- Өөрийн ярих зүйлийн гол санаа, чухал хэсгийг тодорхойл. Энэ нь танд өөртөө итгэлтэй байхад чинь туслах төдийгүй эргэлзээг арилгаж цэгтэй оновчтой тайлбар өгч дэмий маргаан үүсгэхээс сэргийлнэ.
- Сургалтын явцад суралцагсдын болон та бүхний хооронд үл ойлголцох байдал, маргаан үүсч болзошгүй. Энэ үед та шууд эсэргүүцэх бурууг нь нотлохыг илтүлайрах байдал үүсгэх хэрэггүй. Оролцогчдын хооронд үүссэн маргаанд та төвийн байр сууринаас хандаж, аль аль талын байж болох давуу талыг нь болон дутагдалтай талыг тайлбарлан ойлгуулах байдлаар зохицуулан оролцох ёстой. Харин маргаан та болон оролцогчийн хооронд үүссэн бол эсрэг талаа хүлээцтэй сонсож түүний үзэл бодлоос байж болох

сайшаалтай талыг дүгнэн хэлээд, ташаа байгаа хандлага үзлийг нь хэрхэн яагаад ингэж ойлгосныг нь лавлан асууж бурууг нотлох замаар тайлбарлан ойлгуулах нь илүү үр дүнгээ өгдөг.

Сургагч багш ямар ч тохиолдолд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх шууд чиг үүрэг бүхий байгууллагуудын алба хаагчид, сонсогч, оюутнуудад сургалт явуулж байгаа онцлогоо байнга тооцож, жишээ баримт, бодлого дасгал зэргийг аль болох тэдний ажил мэргэжилд ойр дөт хамааралтай байхаар бодож боловсруулах нь чухал. Ингэснээрээ сургалт тэдэнд илүү сонирхолтой, хэрэгцээнд нь нийцтэй болж, үр өгөөж нь нэмэгдэх болно.

**1.1 “ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ,  
ТҮҮНТЭЙ ХИЙХ ОЛОН УЛСЫН ТЭМЦЭЛ, ХҮН ХУДАЛДААЛАХ  
ГЭМТ ХЭРГИЙН КРИМИНОЛОГИ ШИНЖ”  
ХИЧЭЭЛИЙГ ЗААХ НЬ:**

**Хичээлийн төлөвлөгөө:**

**БҮЛЭГ**

# I

## **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ:**

**ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ  
ХЭРГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ,  
ТҮҮНТЭЙ ХИЙХ ОЛОН УЛСЫН  
ТЭМЦЭЛ, КРИМИНОЛОГИЙН  
ЗАРИМ АСУУДАЛ**

---

- 1.1 *Хүний наймааны түүх*
- 1.2 *Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын жишиг*
- 1.3 *Хүүхдийн эрхийн конвенци, нэмэлт протоколын агуулга мөн чанар*
- 1.4 *Хүн худалдаалах гэмт хэргийн онцлог*
- 1.5 *Хүн худалдаалах гэмт хэргийн криминологи шинж*



Д/д	Хичээлийн бүтэц	Хугацаа
1.	Сэдвийн танилцуулга	10 мин
2.	Сэдэвт хамаарал бүхий зарим нэр томъёоны талаар суралцагсадтай ярилцах	20 мин
3.	Онолын мэдлэг олгох /лекц/	30 мин
4.	Асуулт, хариулт /сэдэвтэй холбоотой суралцагсадад ойлгомжгүй асуудлын талаар/	20 мин
5.	Дүгнэлт	10 мин

**Хичээлийг явуулах хэлбэр:**

- Урьдчилан бэлтгэсэн төлөвлөгөөний дагуу сэдвийг ярьж танилцуулах
- Сургалтанд шаардлагатай техник хэрэгслийг ашиглах (компьютер, проектор, дэлгэц гэх мэт)
- Хичээлийн явцад Power point программ дээр бэлтгэсэн Presentation үзүүлэх эсвэл өөр байдлаар бэлтгэсэн материал ашиглах.

**Сэдвийн зорилго:** Хүний наймааны түүх, хүн худалдаалах гэмт хэрэгтэй олон улсын түвшинд болон үндэсний хэмжээнд хийж буй тэмцэл, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр батлагдсан олон улсын гэрээний агуулга, мөн чанар, хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан нөхцлийн талаар суралцагсадад шаардлагатай түвшний ойлголт эзэмшүүлэхэд оршино.

**Сэдвийн агуулга:**

- Хүний наймааны түүх
- Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын жишиг
- Хүүхдийн эрхийн конвенци, нэмэлт протоколын агуулга, мөн чанар
- Хүн худалдаалах гэмт хэргийн онцлог
- Хүн худалдаалах гэмт хэргийн криминологи шинж

**Сэдэвт хамаарал бүхий зарим нэр томъёоны талаар суралцагсадтай ярилцах:**

- Хүний наймаа
- Хүн худалдаалах гэмт хэрэг
- Траффикинг /Trafficking/
- “Цагаан боолын худалдаа”
- Хуурамч үрчлэлт
- Хуурамч гэрлэлт
- Хүчээр гэмт хэрэг үйлдүүлэх
- Хүчээр гуйлгээний гуйлгуулах
- Худалдаалагдсан хүмүүсийн хүчирхийлэлд өртөх хэлбэр /биесийн болон оюун санааны хүчирхийлэл/
- Лондонгийн бага хурлийн тэмдэглэл 1899
- Эмэгтэйчүүд, хүүхдийг худалдахыг хориглосон олон улсын конвенц 1921

12. Үндэстнүүдийн Лиг батлан гаргасан “Боолчлолын эсрэг конвенц” 1927
13. Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагаас батлан гаргасан “Албадан хөдөлмөрийн эсрэг конвенц”
14. “Хүнийг дамжуулан худалдах болон бусдын биеийг үнэлүүлэн ашиглахыг хориглох олон улсын гэрээ” 1949

**Хяналтын асуулт:**

1. Европод хүмүүсийг боол болгон худалдаалахыг эсэргүүцсэн хөдөлгөөн хэдий үеэс эхэлсэн бэ?
2. Хэдэн онд АНУ-д боолчлолыг халсан тухай зарлаж, Үндсэн хуульд хуульчилсан бэ?
3. Монгол улс “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц” буюу Палермогийн протоколд нэгдэн орох шаардлага, ач холбогдлыг тодорхойлно уу?
4. Хүүхдийг худалдах, хүүхдийн биеийг үнэлэх, хүүхдийг садар самоунд сурталчлахын эсрэг хүүхдийн эрхийн тухай конвенц, нэмэлт протоколын /2000/ агуулга, мөн чанарыг тодорхойлно уу?
5. Хүүхдийг хамгаалах болон улс хооронд үрчлэх асуудлаар хамтран ажиллах тухай конвенцийн /1993/ агуулга, мөн чанар
6. Сайн дурын үндсэн дээр гэрлэх, гэрлэх насны доод хязгаар болон гэрлэлтийг бүртгэх тухай конвенцийн /1962/ агуулга, мөн чанар
7. Боолчлол, боолын худалдааг хориглох тухай конвенцийн /1926/ агуулга, мөн чанар, түүхэнд гүйцэтгэсэн үргийг тодорхойлно уу?
8. Боолчлол, боолын худалдаа болон боолчлолтой адилтгах ёс заншлыг устгах тухай конвенцийн /1956/ агуулга, мөн чанар
9. Хүн худалдаалах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар таны бодол?
10. Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэхэд хамгийн ихээр нөлөөлж буй шалтгаан нөхцөл таны бодлоор?
11. Хүн худалдаалах гэмт хэргийн гаралтыг бууруулахын тулд төрийн болон төрийн бус байгууллагаас ямар ямар арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлбэл зүйтэй вэ?

**Сэдвийг үнзгүйрүүлэн судлахад ашиглах материал:**

**1. Хууль, эрхийн баримт бичиг**

1. Монгол Улсын Үндсэн хууль.УБ.,1992
2. БНМАУ-ын Эрүүгийн хууль.1986 /шинэчлэн найруулсан/
3. Монгол Улсын Эрүүгийн хууль.УБ., 2002
4. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль.УБ., 2002
5. Монгол Улсын Донорын тухай хууль.УБ.,2000
6. Улсын Дээд Шүүхийн 2008 оны 03 сарын 26-ны өдрийн 12 тоот тогтоол

7. Улсын Дээд Шүүхийн тогтоолуудын эмхтгэл.УБ.,2008
8. “Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл”.УБ.,1998
9. “Насанд хүрээгүй хүмүүсийн талаарх НҮБ-ын баримт бичгүүд”.УБ.,2003

## **2. Ном, сурах бичиг, гарын авлага, хэвлэлүүд**

1. Г.Совд.“БНМАУ-ын Эрүүгийн эрх зүйн курс”.УБ.,1973
2. С.Жанцан.“Монгол улсын Эрүүгийн эрх зүй”. /схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал/. УБ.,2003
3. С.Жанцан.“Монгол улсын Эрүүгийн эрх зүй” /тусгай анги/.УБ., 2003
4. С.Жанцан. “Монгол улсын Эрүүгийн эрх зүй” /ерөнхий, тусгай анги/ 2005
5. Н.Жанцан.“Кriminologи”.УБ.,2004
6. “Кriminologи”.под.ред А.И.Долговой.М.1997
7. Ц.Цэлмэг.“Кriminologи”.УБ.,2006
8. Г.Совд.“Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар” .УБ., 2003
9. С.Нарангэрэл.“Монгол улсын Эрүүгийн эрх зүй” /ерөнхий анги/. УБ.,1996, 1999
10. С.Нарангэрэл.“Гэмт хэргийг зүйлчлэх шинжлэх ухааны үндэс” УБ.,1988
11. Г.Гантемөр.“Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол”. УБ.,2003
12. Ж.Болдбаатар, З.Төрмандах.“Эрүүгийн эрх зүйн ерөнхий ба тусгай анги”. УБ.,2008
13. З.Төрмандах, С.Гантулга.“Хүн худалдаалах гэмт хэрэг”.УБ.,2008
14. З.Төрмандах, С.Гантулга.“Хүн худалдаалах гэмт хэрэгтэй гүйцэтгэх ажлаар тэмцэх үндэс”.УБ.,2008
15. Эмэгтэйчүүдийг наймаалахын эсрэг эвсэл - GAATW вэб 2003.11.09-ны өдөр <http://lists.partners-intibnet / pipermail - east / 2002 - June / 0002516 html>
16. Trafficking in Persons Report Released by the office to Monitor and Combat trafficking in persons. June 5. 2002.
17. Robyn Emerton Trafficking of woman into Hong Kong for the purpose of Prostitution Preliminari Research findings Centre for Comparative and Public Law.University of Hong Kong.Occasional paper №3, February 2001
18. Adisory Councils of Jurists of the Asia Pacific Forum of National Human Rihts institutions Consideration of the issue of trafficking. Background paper 11- 12.Nov. 2002. New Delhi

### **2.1 “ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ҮНДСЭН ШИНЖ” ХИЧЭЭЛИЙГ ЗААХ НЬ:**

#### **Хичээлийн төлөвлөгөө:**

Д/д	Хичээлийн бүтэц	Хугацаа
1.	Сэдвийн танилцуулга	5 мин
2.	Онолын мэдлэг олгох /лекц/	30 мин



**ХОЁРДУГААР БҮЛЭГ:**

**ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ**

**ХЭРГИЙН ЭРҮҮГИЙН ЭРХ**

**ЗҮЙН ШИНЖ**

---

---

**БҮЛЭГ**

**II**

- 2.1. *Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж*
  - 2.1.1. *Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний объект*
  - 2.1.2. *Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив тал*
  - 2.1.3. *Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний субъект*
  - 2.1.4. *Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив тал*
- 2.2. *Хүн худалдаалах гэмт хэргийн хүндруүлэх болон онцлон хүндруүлэх бүрэлдэхүүн*
- 2.3. *Хүн худалдаалах гэмт хэргийг төсөөтэй гэмт хэргээс ялган зүйлчлэх нь*
- 2.4. *Хүн худалдаалах гэмт хэргийг гадаад орнуудын Эрүүгийн хууль тогтоомжид хуульчилсан байдлыг харьцуулан судлах нь*



3.	Сэдэвт хамаарал бүхий зарим нэр томъёоны талаар суралцагсадтай ярилцах	15 мин
4.	Суралцагсдыг З бүлэгт хуваан бодлого бодуулах	20 мин
5.	Бүлэг бүрийн бодлогын хариуг хэлэлцүүлэх	10 мин
6.	Суралцагсдын бодлого бодсон байдалд үнэлгээ өгөх, тайлбар хийх	10 мин
7.	Суралцагсдын лекцээр олж авсан онолын мэдлэгийг багаттаж, дүгнэх зорилгоор тестын шалгалт авах	

**Хичээлийг явуулах хэлбэр:**

- Урьдчилан бэлтгэсэн төлөвлөгөөний дагуу сэдвийг ярьж танилцуулах
- Сургалтанд шаардлагатай техник хэрэгслийг ашиглах (компьютер, проектор, дэлгэц гэх мэт)
- Хичээлийн явцад Power point программ дээр бэлтгэсэн Presentation үзүүлэх эсвэл өөр байдлаар бэлтгэсэн материал ашиглах.

**Сэдвийн зорилго:** Хүн худалдаалах гэмт хэрэгтэй хийх эрүүгийн эрх зүйн тэмцэл, гэмт хэргийн бүрэлдэхүүний үндсэн шинжийн талаар онолын ойлголтыг өгөх, энэ төрлийн гэмт хэргийг төсөөтэй гэмт хэргүүдээс ялган зүйлчлэх, улмаар ялыг ялгамжтай оногдуулах чадвар, дадал суралцагсадад эзэмшүүлэхэд оршино.

**Сэдвийн агуулга:**

- Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний үндсэн шинж
- 1.1 Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний объект
- 1.2 Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив тал
- 1.3 Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний субъект
- 1.4 Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив тал

**Сэдэвт хамаарал бүхий зарим нэр томъёоны талаар суралцагсадтай ярилцах:**

- Гэмт хэргийн бүрэлдэхүүний үндсэн шинж
- Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний объект /ерөнхий, төрлийн, шууд объект/
- Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив тал
- Хүн худалдаалах
- Хүн худалдан авах
- Хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн
- Хууран мэхэлсэн
- Эмзэг байдлыг далимдуулсан
- Элсүүлсэн
- Тээвэрлэсэн
- Дамжуулсан
- Орогнуулсан

13. Хүлээн авсан
14. Эрх мэдлээ урвуулан ашиглах
15. Эрхшээлдээ байгаа
16. Хил давуулан
17. Биеийг нь үнэлүүлэх
18. Албадан хөдөлмөр хийлгэх
19. Боолчлох
20. Боолчлолтой ижил нөхцөлд байлгах
21. Эд эрхтнийг авч ашиглах
22. Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний субъект
23. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаар, хэрэг хариуцах чадвар
24. Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив тал
25. Шууд ба шууд бус санаа
26. Ашиг олох мөлжих зорилгоор

**Хяналтын асуулт:**

1. Хүн худалдаалах гэмт хэргийн Эрүүгийн эрх зүйн тэмцэл хэдий үеэс эхэлсэн гэж үздэг вэ?
2. Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий буюу нийтлэг, төрлийн, шууд объектыг тодорхойлно уу?
3. Хүн худалдаалах гэмт хэргийн субъектыг эрхийн ямар чадвар, чадамжтай байхыг шаарддаг вэ?
4. Хүн худалдаалах болон хүн хулгайлах гэмт хэргүүд нь гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын шинжээрээ хэрхэн ялгагдах вэ?
5. Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүнийг зөв тодорхойлохын ач холбогдлыг тодорхойлно уу?
6. Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талыг тодорхойлох шинжүүдэд /үйлдэл, эс үйлдэхүй, хор уршиг, шалтгаант холбоо, гэмт хэрэг үйлдсэн газар орон, цаг, зэвсэг хэрэгсэл, арга, нөхцөл байдал/ хамаардаг бол эдгээрийг тодорхойлон хэлнэ үү?
7. Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талыг тодорхойлох шинжүүдэд /гэм буруу, гэмт хэрэг үйлдсэн сэдэлт, зорилго, гэмт хрэг үйлдэх үеийн гэмт этгээдийн сэтгэл санааны байдал/ хамаардаг бол эдгээрийг тодорхойлон хэлнэ үү?
8. Хүн худалдаалах гэмт хэрэг нь гэмт хэргийн бүрэлдэхүүний ангилалын төрлийн хувьд хэлбэрийн бүрэлдэхүүнтэй, материаллаг бүрэлдэхүүнтэй эсэх?

**БОДЛОГЫН ХАРИУ**

**Бодлого 1**

Доржид эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй. Дорж 17 настай гэж

бодлогын нөхцөлд өгсөн учраас Дорж нь эрүүгийн хариуцлага хүлээх Монгол улсын Эрүүгийн хуулиар тогтоосон насанд хүрсэн.

Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний субъект нь ердийн буюу 16 насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай Монгол улсын иргэн, харьяалалгүй хүн буюу гадаад улсын иргэн байх бөгөөд Монгол улсын Эрүүгийн хуулийн 21-р зүйлд заасан эрүүгийн хариуцлага хүлээлгэх наслын хязгаарт Дорж нь хүрсэн байна.

Төрөөгийн үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй. Төрөө нь бусдыг хүн худалдаалах үйлдэл хийхэд нь зоригжуулж, мөнгө олох хялбар арга гэдгийг хэлж, мөнгөтэй болчихвол АНУ явж сайхан амьдрах болно гэж Доржийн дотоод сэтгэл зүйг ашиглан өдөөн түлхэж, идэвхтэй нөлөөлж байгаа нь гэмт хэргийн хамтран оролцогчдын **хатгагч** мөн. /Эрүүгийн хуулийн 35-р зүйлийн 35.4/ Хатгах үйл ажиллагаа нь ярьж сануулах, тухайн үйлдэл хийхийг итгүүлэх, хүсэх, мэхлэх, заналхийлэх гэх мэт олон аргаар илэрч болно.

**Улсын Дээд Шүүхийн 2003 оны 05 сарын 05 ны 10 дугаар тогтоолд тайлбарласнаар:** “Хатгагч” гэдэгт гэмт хэрэг үйлдэхэд бусдыг элдэв аргаар өдөөн түлхсэн, зоригжуулсан идэвхтэй үйлдэл хийсэн этгээдийг ойлгоно. Эдгээр аргын:

- “...ятгах...” гэдэг нь гэмт хэрэг үйлдэх талаар бусдад зориг шийдэмгий бодлыг төрүүлэхийн тулд элдэв байдлаар өөрийн санаа бодлыг итгүүлэн үнэмшүүлэх, тухайн этгээдийн гэмт хэрэг үйлдэх эсэх тухай эргэлзээ тээнэгэлзлийг арилган, гэмт хэрэг үйлдэхэд эргэлт буцалтгүй болгоход чиглэсэн ятгалга хийсэн байхыг ойлгоно.

- “...заналхийлэх...” гэдэг нь бусдыг айлган сүрдүүлэх, хүч хэрэглэх, сэтгэл санааны дарамтад оруулах зэргээр өөрийнхөө санаа бодлыг тулган гэмт хэрэгт түлхэн оруулах буюу гэмт хэрэг үйлдэхээс өөр аргагүй байдалд хүргэх байдлаар илэрнэ.

- “...бусад аргаар...” гэдэг нь гэмт хэрэг үйлдэх санаа бодол төрүүлэх, шийдвэр гаргахад өдөөн хатгаж хор шарыг нь хөдөлгөх, уриалах, бухимдал уцаарыг төрүүлэх, шаналгах зэрэг аргуудыг хамруулан ойлгоно.

Охиныг хууран мэхэлж элсүүлсэн үйлдэл нь Улсын Дээд Шүүхийн тогтоолоос үзэхэд төгс үйлдэгдсэнд тооцохоор тайлбарласан байна. Мөн 113.1 хэлбэрийн бүрэлдэхүүнтэй, 113-р зүйлийн онц хүндрүүлэх бүрэлдэхүүн нь материаллаг бүрэлдэхүүнтэй байна.

## **Бодлого 2**

Батад эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй. Учир нь Бат нь БНХАУ-ын иргэн Ли-д мөрийтэй тоглоомны өрөндөө Цэцэг гэгч эмэгтэйг өгсөн үйлдэл нь Улсын Дээд Шүүхийн 2008 оны 03 сарын 26-ны өдрийн 12 тоот тогтоолд тайлбарласнаар: “Хүн худалдаалах” гэдэгт ямар нэгэн үргийн гүйцэтгэлд тооцож /өрөнд өгөх г.м/ хүнийг бусад хүмүүсийн мэдэлд бүр мөсөн буюу тодорхой хугацаагаар шилжүүлэхийг ойлгоно гэсэн байдал. Монгол улсын Эрүүгийн хуулийн 113-р зүйлээр зүйлчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Цэцэгийн худалдаалагдахыг зөвшөөрсөн нь Батыг эрүүгийн хариуцлагаас

чөлөөлөх үндэслэл болохгүй. Учир нь Монгол улсын Эрүүгийн хуулийн 113-р зүйлийн тайлбарт “Энэ хуулийн 113.1-д заасан аливаа арга хэрэглэсэн бол хохирогч худалдагдахыг зөвшөөрсөн эсэхийг үл харгалзан гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэсэн байdag бөгөөд Бат удаа дараа Цэцэгийн гэр бүлийнхнийг ална гэх мэтээр сүрдүүлсэн нь Эрүүгийн хуулийн 113.1-д заасан хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсний улмаас хохирогч зөвшөөрсөн байна.

### Бодлого 3

Нэг хүнийг 400 доллараар бодож мөнгө авсан үйлдэл нь Улсын Дээд Шүүхийн 2008 оны 03 сарын 26-ны өдрийн 12 тоот тогтоолд тайлбарласнаар “Ашиг олох зорилгоор” хүн худалдаалах замаар өөртөө болон бусад этгээдэд эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус ашигтай байдал, орлого бий болгох, 500-1000 долларын цалинтай, орон байр, хоол, хувцсаар хангана гэж хуuran мэхэлж, энэ нь гадаадад ажиллахад зуучилна гэсэн хэлбэрээр илэрсэн байна. Хуuran мэхлэх аргаар хүнийг элсүүлсэн, тээвэрлэсэн, дамжуулсан үйлдэл нь хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын шинжийг бүрдүүлж байна. Гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектын тухайд бодлогын нөхцөлд өгөөгүй учраас эрүүгийн хариуцлага хүлээх насанд хүрсэн гэж үзэж байна. Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талын тухайд хүн худалдаалах гэмт хэргийн заавал байх шинж нь зорилго юм. Эрүүгийн хуулийн 113-р зүйлд 2 төрлийн зорилгыг тухайлан зааж өгсөн. Энэ нь ашиг олох, мөлжих юм. Бодлогын нөхцлөөс үзэхэд энэхүү зорилго хангагдсан байна. Иймд хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг бүрдүүлж байгаа тул Монгол улсын Эрүүгийн хуулийн 113-р зүйлээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй.

Эдгээр залуус нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч мөн. Монгол улсын ЭБШХуулийн 42-р зүйлд заасан “Гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийн хохирогч“ гэнэ.

### МЭДЛЭГ ШАЛГАХ СОРИЛЫН ТУЛХҮҮР:

№	Хариу	Хариултын үндэслэл, тайлбар
1	B	Эрүүгийн хуулийн 17.3 Энэ хуулийн тусгай ангид нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тorgох, хоёр зуун тавин нэгээс таван зуун цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан гэмт хэргийг хүндэвтэр гэмт хэрэг гэнэ.
2	E	
3	C	
4	D	Эрүүгийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т заасан хүмүүс дипломат дархан эрх эдэlnэ.

5	C	Монгол улсын Үндсэн хуулиас бусад хуульд УДШ албан ёсны тайлбар хийнэ.
6	C	Эрүүгийн хуулийн 10-р зүйлийн 10.1-д заасан
7	C	Эрүүгийн хуулийн 15-р зүйлийн 15.1-т “Монгол улсын хилийн гадна гэмт хэрэг үйлдсэн бөгөөд тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьялалгүй хүнийг эрүүгийн хариуцлага хүлээлгэх буюу ял эдлүүлэхээр Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу гадаад улсад шилжүүлж болно” гэж заасан.
8	D	Эрүүгийн хуулийн 20-р зүйлийн 20.1-д зааснаар “...Эрүүгийн хуулиар тогтоосон насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь шүүхээр нотлогдсон этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.
9	A	Эрүүгийн хуулийн 20-р зүйлийн 20.1-д зааснаар эрүүгийн хариуцлага хүлээх этгээдийн нэг гол шинж уг этгээд нь Эрүүгийн хуулиар тогтоосон насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай байх явдал мөн.
10	D	Эрүүгийн хуулийн 21-р зүйлийн 21.1

**Сэдвийг гүнзгийрүүлэн судлахад ашиглах материал:****1. Хууль, эрхийн баримт бичиг**

1. Монгол Улсын Үндсэн хууль.УБ.,1992
2. БНМАУ-ын Эрүүгийн хууль.1986 /шинэчлэн найруулсан/
3. Монгол Улсын Эрүүгийн хууль.УБ., 2002
4. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль.УБ., 2002
5. Улсын Дээд Шүүхийн 2008 оны 03 сарын 26-ны өдрийн 12 тоот тогтоол
6. Улсын Дээд Шүүхийн тогтоолуудын эмхтгэл.УБ.,2008

**2. Ном, сурх бичиг, гарын авлага, хэвлэлүүд**

1. Г.Совд.“БНМАУ-ын Эрүүгийн эрх зүйн курс”.УБ.,1973
2. С.Жанцан.“Монгол улсын Эрүүгийн эрх зүй”. /схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал/. УБ.,2003
3. С.Жанцан.“Монгол улсын Эрүүгийн эрх зүй” /тусгай анги/.УБ., 2003
4. С.Жанцан. “Монгол улсын Эрүүгийн эрх зүй” /ерөнхий, тусгай анги/ 2005
5. Г.Совд.“Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар” .УБ., 2003
6. С.Наангэрэл.“Монгол улсын Эрүүгийн эрх зүй”/ерөнхий анги/.УБ.,1996, 1999
7. С.Наангэрэл.“Гэмт хэргийг зүйлчлэх шинжлэх ухааны үндэс“УБ.,1988
8. Г.Гантөмөр.“Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол”. УБ.,2003
9. Ж.Болдбаатар, З.Төрмандах.“Эрүүгийн эрх зүйн ерөнхий ба тусгай анги”. УБ.,2008
10. З.Төрмандах, С.Гантулга.“Хүн худалдаалах гэмт хэрэг”.УБ.,2008
11. З.Төрмандах, С.Гантулга.“Хүн худалдаалах гэмт хэрэгтэй гүйцэтгэх ажлаар

тэмцэх үндэс”. УБ., 2008

**2.2 “ХҮН ХУДАЛАЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХҮНДРҮҮЛЭХ БОЛОН  
ОНЦЛООН ХҮНДРҮҮЛЭХ БҮРЭЛДЭХҮҮН”  
ХИЧЭЭЛИЙГ ЗААХ НЬ:**

**Хичээлийн төлөвлөгөө:**

<i>Д/д</i>	<i>Хичээлийн бүтэц</i>	<i>Хугацаа</i>
1.	Сэдвийн танилцуулга	5 мин
2.	Онолын мэдлэг олгох /лекц/	30 мин
3.	Сэдэвт хамаарал бүхий зарим нэр томъёоны талаар суралцагсадтай ярилцах	15 мин
4.	Суралцагсдыг 3 бүлэгт хуваан бодлого бодуулах	20 мин
5.	Бүлэг бүрийн бодлогын хариуг хэлэлцүүлэх	10 мин
6.	Суралцагсдын бодлого бодсон байдалд үнэлгээ өгөх, тайлбар хийх	10 мин

**Хичээлийг явуулах хэлбэр:**

- Урьдчилан бэлтгэсэн төлөвлөгөөний дагуу сэдвийг ярьж танилцуулах
- Сургалтанд шаардлагатай техник хэрэгслийг ашиглах (компьютер, проектор, дэлгэц гэх мэт)
- Хичээлийн явцад Power point программ дээр бэлтгэсэн Presentation үзүүлэх эсвэл өөр байдлаар бэлтгэсэн материал ашиглах.

**Сэдвийн зорилго:** Хүн худалдаалах гэмт хэргийн хүндруүлэх болон онцлон хүндруүлэх бүрэлдэхүүний талаар онолын ойлголтыг суралцагсдад эзэмшүүлэхэд оршино.

**Сэдвийн агуулга:**

1. Хүн худалдаалах гэмт хэргийн хүндруүлэх бүрэлдэхүүн
2. Хүн худалдаалах гэмт хэргийн онцлон хүндруүлэх бүрэлдэхүүн

**Сэдэвт хамаарал бүхий зарим нэр томъёоны талаар суралцагсадтай ярилцах:**

1. Насанд хүрээгүй хүн
2. Хоёр ба түүнээс олон хүнийг худалдаалах
3. Хулгайлах
4. Эрх мэдлээ урвуулан ашиглах
5. Эрхшээлдээ байгаа хүнийг худалдаалах
6. Давтан
7. Бүлэглэж буюу үгсэн тохиролцсон бүлэг үйлдсэн
8. Хүнийг хил давуулан худалдаалах
9. Зохион байгуулалттай бүлэг
10. Гэмт бүлэглэл
11. Хүнд хор уршиг учирсан

**Хяналтын асуулт:**

1. Насанд хүрээгүй хүнийг худалдаалсан гэдэгт гэмт этгээд насанд хүрээгүй хүнийг худалдаалж байна гэдгийг мэдсэн байхыг заавал шаардах уу?
2. Насанд хүрээгүй хүн гэдэгт хэдээс хэдэн настын ямар субъектыг хамааруулж ойлгох вэ?
3. Бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг хүн худалдаалах гэмт хэргийг үйлдсэн гэдгийг хэрхэн ойлгох вэ?
4. Хүн худалдаалах гэмт хэргийг давтан үйлдсэн гэдгийг хэрхэн ойлгох вэ?
5. Эрүүгийн хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн, ялгүй болсон, ялгүйд тооцогдсон этгээд гэмт хэрэг шинээр үйлдсэн давтан гэмт хэрэг болох уу?
6. Монгол улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид хүн худалдаалах гэмт хэргийн онцлон хүндруүлэх бүрэлдэхүүнийг хэрхэн хуульчилсан бэ?
7. Зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэлийн ялгаатай болон төстэй талыг

- нэрлэнэ үү?
8. Хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан гэдгийг хэрхэн ойлгох вэ?
  9. “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцэд” зохион байгуулалттай бүлэг, зохион байгууллать гэмт бүлэглэл гэдгийг хэрхэн тодорхойлсон байdag вэ?
  10. Зохион байгуулалттай гэмт байгуулал, бүлэглэл, бүлэг нь зохион байгуулалттай бүлэг, зохион байгуулалттай бүлэглэл, зохион байгуулалттай нийгэмлэг буюу байгууллага гэсэн бүтэцтэй байх бөгөөд гэмт хэрэг үйлдэж олсон орлого нь тэдний амьдрах эх сурвалж буюу хэрэгсэл болсон байdag талаар ямар эрдэмтэн судлаачид, ямар бүтээлдээ бичсэн байdag вэ?

## **БОДЛОГЫН ХАРИУ**

### **Бодлого 1**

Хуягт эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй. Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн 113.1-ээр зүйлчлэн эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь зүйтэй юм.

Мөрдөн байцаагчийн Хуягт Эрүүгийн хуулийн 113.2.5-аар буюу давтан хүн худалдаалах гэмт хэргийг үйлдсэн гэж үзэж эрүүгийн хэрэг үүсгэсэн нь үндэслэлгүй. Учир нь Эрүүгийн хуулийн 18.2 “Хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн, ялгүй болсон, ялгүйд тооцогдсон этгээд гэмт хэрэг шинээр үйлдсэн нь давтан гэмт хэрэг болохгүй” гэж заасан байdag.

### **Бодлого 2**

Сүхээгийн өмгөөлөгчийн гомдол үндэслэлгүй. Мөрдөн байцаагч насанд хүрээгүй хүнийг худалдаалсан үйлдэлд нь Сүхээд Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн 113.2.1-р эрүүгийн хэрэг үүсгэсэн нь үндэслэлтэй. Насанд хүрээгүй хүн гэдэгт 18 насанд хүрээгүй Монгол улсын иргэн, гадаадын иргэн, харьялалгүй хүнийг хамааруулан ойлгоно. Бодлогын нөхцөлд өгснөөр Хуяг М-ийг насанд хүрээгүй гэдгийг мэдэж байсан.

### **Бодлого 3**

БатӨ-д БНХАУ-д биеэ үнэлэхийг хэлж, урьдчилан мэдэгдсэн, ашиг, орлогын тодорхой хувийг түүнд өгч, эрх, эрх чөлөө нь бүрэн хязгаарлагдсан шинжгүй байсан зэргийг Улсын Дээд Шүүхийн 2008 оны 03 сарын 26-ны өдрийн 12 тоот тайлбарт тайлбарласнаас үзэхэд хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, харин Эрүүгийн хуулийн 124-р зүйл “Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах” гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжтэй байна.

Ийм учраас хүн худалдаалах гэмт хэргийн 2 ба түүнээс олон хүнийг худалдаалах хүндрүүлэх нөхцөл байдалд хамааarahгүй ба харин Батын иргэн Б-г хил давуулан худалдаалсан үйлдэлд Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн 113.3, мөн Ө-г биеэ үнэлэхэд зуучилсан, орон байр бусад зүйлээр үйлчилсэн үйлдэлд

Эрүүгийн хуулийн 124-р зүйлийн 124.2-р давхар зүйлчилвэл зохино.

**МЭДЛЭГ ШАЛГАХ СОРИЛЫН ТҮЛХҮҮР:**

№	Xариу	Xариултын үндэслэл, тайлбар
1	Е	
2	В	Эрүүгийн хуулийн нэг зүйл, түүний нэг хэсэгт заасан гэмт хэргийг 2 буюу түүнээс дээш удаа үйлдсэнийг давтан гэмт хэрэг гэнэ. /Эрүүгийн хуулийн 18.1/
3	В	Эрүүгийн хуулийн 18.2-т Хуульд заасан үндэслэл журмын дагуу эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдсөн, ялгүй болсон, ялгүйд тооцогдсон этгээд шинээр гэмт хэрэг үйлдвэл давтан гэмт хэрэг болохгүй.
4	С	
5	А	Улсын Дээд Шүүхийн 2008 оны 03 сарын 26-ны өдрийн 12 тоот тогтоол

*Сэдвийг үзүүлэхэд судлахад ашиглах материал:*

**1. Хууль, эрхийн баримт бичиг**

1. БНМАУ-ын Эрүүгийн хууль.1986 /шинэчлэн найруулсан/
2. Монгол Улсын Эрүүгийн хууль.УБ., 2002
3. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль.УБ., 2002
4. Улсын Дээд Шүүхийн 2008 оны 03 сарын 26-ны өдрийн 12 тогтоол

**2. Ном, сурх бичиг, гарын авлага, хэвлэлүүд**

1. Г.Совд.“БНМАУ-ын Эрүүгийн эрх зүйн курс”.УБ.,1973
2. С.Жанцан.“Монгол улсын Эрүүгийн эрх зүй”. /схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал/. УБ.,2003
3. С.Жанцан.“Монгол улсын Эрүүгийн эрх зүй” /тусгай анги/.УБ., 2003
4. С.Жанцан. “Монгол улсын Эрүүгийн эрх зүй” /ерөнхий тусгай анги/ 2005
5. С.Нарангэрэл.“Монгол улсын Эрүүгийн эрх зүй”/ерөнхий анги/.УБ.,1996, 1999
6. С.Нарангэрэл.“Гэмт хэргийг зүйлчлэх шинжлэх ухааны үндэс”УБ.,1988
7. Г.Совд.“Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар” .УБ., 2003
8. Г.Гантөмөр.“Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол”. УБ.,2003
9. Д.Адъяабазар.“Мафи”/Гэмт байгууллага/.УБ.,1999
10. Д.Адъяабазар, З.Төрмандах.“Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үндэс”.УБ.,2005
11. Ж.Болдбаатар, З.Төрмандах.“Эрүүгийн эрх зүйн ерөнхий ба тусгай анги”. УБ.,2008

12. З.Төрмандах, С.Гантулга.“Хүн худалдаалах гэмт хэрэг”.УБ.,2008
13. З.Төрмандах, С.Гантулга.“Хүн худалдаалах гэмт хэрэгтэй гүйцэтгэх ажлаар тэмцэх үндэс”.УБ.,2008

**2.3 “ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ТӨСӨӨТЭЙ  
ГЭМТ ХЭРГҮҮДЭЭС ЯЛГАН ЗҮЙЛЧЛЭХ НЬ”  
ХИЧЭЭЛИЙГ ЗААХ НЬ:**

**Хичээлийн төлөвлөгөө:**

<i>Д/д</i>	<i>Хичээлийн бүтэц</i>	<i>Хугацаа</i>
1.	Сэдвийн танилцуулга	5 мин
2.	Онолын мэдлэг олгох /лекц/	20 мин
3.	Суралцагсдыг 3-4 бүлэгт хуваан бодлого бодуулах	20 мин
4.	Бүлэг бүрийн бодлогын хариуг хэлэлцүүлэх	20 мин
5.	Суралцагсдын бодлого бодсон байдалд үнэлгээ өгөх, тайлбар хийх	20 мин
6.	Дүгнэлт	5 мин

**Хичээлийг явуулах хэлбэр:**

- Урьдчилан бэлтгэсэн төлөвлөгөөний дагуу сэдвийг ярьж танилцуулах
- Сургалтанд шаардлагатай техник хэрэгслийг ашиглах (компьютер, проектор, дэлгэц гэх мэт)
- Хичээлийн явцад Power point программ дээр бэлтгэсэн Presentation үзүүлэх эсвэл өөр байдлаар бэлтгэсэн материал ашиглах.

**Сэдвийн зорилго:** Хүн худалдаалах гэмт хэргийг бусад төсөөтэй гэмт хэргээс ялган

зүйлчлэх нь энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгчдэд эрүүгийн хариуцлага зөв оноох, эрүүгийн хариуцлагын зорилтыг хангах, зөрчигдсөн эрхийг сэргээх, хуулийн байгууллагын ажилтнуудад нэг мөр ойлголт өгөх зэрэг ихээхэн ач холбогдолтой бөгөөд энэхүү чадвар дадалыг суралцаагсдад эзэмшүүлэхэд оршино.

### **Сэдвийн агуулга:**

1. Хүн худалдаалах гэмт хэргийг /Эрүүгийн хуулийн 113-р зүйл/ хүн хулгайлах гэмт хэргээс /Эрүүгийн хуулийн 108-р зүйл/ ялган зүйлчлэх нь
2. Хүн худалдаалах гэмт хэргийг /Эрүүгийн хуулийн 113-р зүйл/ хүнийг хууль бусаар хорих гэмт хэргээс /Эрүүгийн хуулийн 109-р зүйл/ ялган зүйлчлэх нь
3. Хүн худалдаалах гэмт хэргийг /Эрүүгийн хуулийн 113-р зүйл/ насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, биеэ үнэлэх, тэнүүчлэл, гуйланчлал, гуйланчлалд татан оруулах гэмт хэргээс /Эрүүгийн хуулийн 115-р зүйл/ ялган зүйлчлэх нь
4. Хүн худалдаалах гэмт хэргийг /Эрүүгийн хуулийн 113-р зүйл/ хүн барьцаалах гэмт хэргээс /Эрүүгийн хуулийн 112-р зүйл/ ялган зүйлчлэх нь
5. Хүн худалдаалах гэмт хэргийг /Эрүүгийн хуулийн 113-р зүйл/ биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргээс /Эрүүгийн хуулийн 124-р зүйл/ ялган зүйлчлэх нь

### **Хяналтын асуулт:**

1. Хүн худалдаалах болон хүн хулгайлах гэмт хэргүүд нь гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив талын шинжээрээ хэрхэн ялгагддаг вэ?
2. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдыг тээвэрлэгчид болон хүлээн авагчид өөрсдийн эрхшээлдээ байлган хүссэнээрээ ашиглаж, тэдний баримт бичгийг хураан авч, өлсгөж хорьдог байсан нь мөрдөн байцаалтын шатанд тогтоогдсон тохиолдолд хэрхэн зүйлчлэх вэ?
3. Хүн худалдаалах болон насанд хүрээгүй хүнийг согтуурал, мансуурал, биеэ үнэлэх, тэнүүчлэл, гуйланчлал, гуйланчлалд татан оруулах гэмт хэргүүд нь гэмт хэргийн бүрэлдэхүүний төрлийн болон шууд обьектоороо хэрхэн ялгагдах вэ?
4. Хүн худалдаалах гэмт хэргийг биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргээс хэрхэн ялган зүйлчлэх вэ?
5. Хүнийг худалдаалах зорилготойгоор хулгайлсан тохиолдолд хэрхэн зүйлчлэх вэ?
6. Хүн барьцаалсан, барьцаалсан хүнийг өөрийн мэдэлд байлгах үедээ ашиг олох зорилгоор бусдад худалдаалсан бол хэрхэн зүйлчлэх вэ?

## **БОДЛОГЫН ХАРИУ**

### **Бодлого 1**

Хүрэл Сүрэнг БНХАУ-ын иргэн Жан-д худалдаалах зорилготойгоор хулгайлсан үйлдэл нь Монгол улсын Эрүүгийн хуулийн 113-р зүйлийн 113.2.3-т заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй хүн хулгайлах гэмт хэрэг мөн бөгөөд мөн хуулийн 108-р зүйлд заасан Хүн хулгайлах гэмт хэргээс хүнийг худалдаалах зорилготой байдгаараа ялгагдана.

Хүнийг худалдаалах зорилгоор хулгайлсан нь энэ гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн тул энэ тохиолдолд Эрүүгийн хуулийн 108-р зүйлээр давхар зүйлчлэхгүй.

Хэрэв Хүрэл Сүрэнг худалдаалах зорилгогүйгээр хулгайлан, дараагаар нь худалдаалсан бол Эрүүгийн хуулийн 108, 113-р зүйлээр давхар зүйлчлэнэ.

Хүрэл Сүрэнг худалдаалах зорилгоор хулгайлаад хил давуулан худалдаалахдаа хууль бусаар Монгол улсын хил нэвтрүүлсэн бол Эрүүгийн хуулийн 108, 113 дугаар зүйл, мөн хуулийн 89-р зүйлээр давхар зүйлчилнэ.

### **Бодлого 2**

Готов охидыг автомашинаар Зам Үүд рүү тээвэрлэхэд жолооч Бат хүн худалдаалж байгааг мэдэж байсан бол түүнд Монгол улсын Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн 113.1-р эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Хүн худалдаалах гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын “тээвэрлэсэн” үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй бөгөөд Улсын Дээд Шүүхийн 2008 оны 03 сарын 26-ны өдрийн 12 тоот тогтоолд “тээвэрлэсэн” гэж хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд худалдаалагдаж буй хүнийг нэг газраас нөгөөд бүх төрлийн тээврийн хэрэгслээр ил болон далд хэлбэрээр зөөвөрлөхийг ойголгохоор тайлбарласан байна.

Дээрх тайлбараас үзэхэд жолооч Бат хүн худалдаалж байгааг мэдээгүй тохиолдолд түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлгүй.

Готов охидыг Замын Үүд сум руу өөрийн машинаар тээвэрлэсэн нь түүний гэмт үйлдлийн зөвхөн нэг хэсэг болно.

### **Бодлого 3**

Б-д эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй. Б-д Монгол улсын Эрүүгийн хуулийн 124-р зүйлээр зүйлчлэн эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Учир нь Б-ийн үйлдэлд Эрүүгийн хуулийн 113-р зүйлд заасан “биеийг нь үнэлүүлэх” үйлдлийн шинж үгүйсгэгдэж байна. Болороо БНХАУ-д бие үнэлнэ гэдгийг урьдчилан мэдэж байсан, бие үнэлж олсон орлогын тодорхой хувийг өөртөө авч байсан зэрэг нь Улсын Дээд Шүүхийн 2008 оны 03 сарын 26-ны өдрийн Монгол улсын Эрүүгийн хуулийн 113-р зүйлийг тайлбарласан 12 тоот тогтоолтой нийцэж байгаа болно.

### **Бодлого 4**

Д нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 33-р зүйлд заасны дагуу хүн худалдаалахаас сайн дураараа төгс татгалзсан боловч мөн хуулийн 33.2-т заасны

дагуу Б-ийн биед санаатайгаар хөнгөн гэмтэл учруулсандаа Эрүүгийн хуулийн 99 дүгээр зүйлээр эрүүгийн хариуцлага хүлээнэ.

**Сэдвийг гүнзгийрүүлэн судлахад ашиглах материал:**

**1. Хууль, эрхийн баримт бичиг**

1. БНМАУ-ын Эрүүгийн хууль.1986 /шинэчлэн найруулсан/
2. Монгол Улсын Эрүүгийн хууль.УБ., 2002
3. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль.УБ., 2002
4. Монгол Улсын Гүйцэтгэх ажлын тухай хууль.УБ.,1998
5. Монгол Улсын Донорын тухай хууль.УБ.,2000
6. Монгол Улсын Зар сурталчилгааны тухай хууль.УБ.,2002
7. Монгол улсын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль.УБ.,1998
8. Улсын Дээд Шүүхийн 2008 оны 03 сарын 26-ны өдрийн 12 тоот тогтоол

**2. Ном, сурх бичиг, гарын авлага**

1. Г.Совд.“БНМАУ-ын Эрүүгийн эрх зүйн курс”.УБ.,1973
2. С.Жанцан.“Монгол улсын Эрүүгийн эрх зүй”. /схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал/. УБ.,2003
3. С.Жанцан.“Монгол улсын Эрүүгийн эрх зүй” /тусгай анги/.УБ., 2003
4. С.Жанцан. “Монгол улсын Эрүүгийн эрх зүй” /ерөнхий тусгай анги/ 2005
5. С.Нарангэрэл.“Монгол улсын Эрүүгийн эрх зүй”/ерөнхий анги/.УБ.,1996, 1999
6. С.Нарангэрэл.“Гэмт хэргийг зүйлчлэх шинжлэх ухааны үндэс”УБ.,1988
7. Г.Совд.“Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар” .УБ., 2003
8. Г.Гантөмөр.“Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол”. УБ.,2003
9. Д.Адъяабазар.“Мафи” /Гэмт байгууллага/.УБ.,1999
10. Д.Адъяабазар, З.Төрмандах.“Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үндэс”.УБ.,2005
11. Ж.Болдбаатар, З.Төрмандах.“Эрүүгийн эрх зүйн ерөнхий ба тусгай анги”. УБ.,2008
12. З.Төрмандах, С.Гантулга.“Хүн худалдаалах гэмт хэрэг”.УБ.,2008
13. З.Төрмандах, С.Гантулга.“Хүн худалдаалах гэмт хэрэгтэй гүйцэтгэх ажлаар тэмцэх үндэс”.УБ.,2008

**2.4 “ХҮН ХУДАЛДАЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ГАДААД ОРНУУДЫН  
ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИД ХУУЛЬЧИЛСАН БАЙДЛЫГ  
ХАРЬЦУУЛАН СУДЛАХ НЬ” ХИЧЭЭЛИЙГ ЗААХ НЬ:**

**Хичээлийн төлөвлөгөө:**

Д/д	Хичээлийн бүтэц	Хугацаа
1.	Сэдвийн танилцуулга	5 мин

2.	Онолын мэдлэг олгох /лекц/	20 мин
3.	Суралцагсдыг 3-4 бүлэгт хуваан гадаад орнуудын Эрүүгийн хууль тогтоомжуудад харьцуулалт хийлгэх	20 мин
4.	Хуулиудын харьцуулалтын талаар харилцан ярилцах	15 мин
5.	Суралцагсдаар Эрүүгийн хуулийн төсөл боловсруулах	20 мин
6.	Дүгнэлт	10 мин

**Хичээлийг явуулах хэлбэр:**

- Урьдчилан бэлтгэсэн төлөвлөгөөний дагуу сэдвийг ярьж танилцуулах
- Сургалтанд шаардлагатай техник хэрэгслийг ашиглах (компьютер, проектор, дэлгэц гэх мэт)
- Хичээлийн явцад Power point программ дээр бэлтгэсэн Presentation үзүүлэх эсвэл өөр байдлаар бэлтгэсэн материал ашиглах.

**Сэдвийн зорилго:** Хууль тогтоомжийг харьцуулан дүн шинжилгээ хийх, хуулийн төсөл боловсруулах чадвар, дадал суралцагсдад эзэмшүүлэхэд оршино.

**Сэдвийн агуулга:**

1. Япон улсын Эрүүгийн хуульд хүн худалдаалах гэмт хэргийг хуульчилсан байдал, харьцуулсан судалгаа
2. БНХАУ-ын Эрүүгийн хуульд хүн худалдаалах гэмт хэргийг хуульчилсан

- байдал, харьцуулсан судалгаа
3. ОХУ-ын Эрүүгийн хуульд хүн худалдаалах гэмт хэргийг хуульчилсан байдал
  4. Украян улсын Эрүүгийн хуульд хүн худалдаалах гэмт хэргийг хуульчилсан байдал
  5. Дани улсын Эрүүгийн хуульд хүн худалдаалах гэмт хэргийг хуульчилсан байдал
  6. Израйл улсын Эрүүгийн хуульд хүн худалдаалах гэмт хэргийг хуульчилсан байдал

**Хяналтын асуулт:**

1. Дэлхийн улс орнуудыг хүн худалдаалах гэмт хэргийн гаралтын түвшин, түүний эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үр нөлөөг харгалзан З бүст хуваадаг бөгөөд Монгол улс хэддүгээр бүст багтаж байна вэ?
2. Монгол улс хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх дагнасан хуультай болохын ач холбогдлыг тодорхойлно уу?
3. Монгол улсын Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн гэмт буруутай этгээдэд оногдуулж буй эрүүгийн ялын хэмжээг ихэсгэх шаардлагатай юу?
4. Украян улсын Эрүүгийн хуулийн 149-р зүйлд хүн худалдаалах гэмт хэргийг хуурамч гэрлэлт, үрчлэлтээр халхавчлан үйлдсэн тохиолдолд хүндрүүлэхээр заасан байдаг бол Монгол улсын Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлийн хүндрүүлэх болон онцлон хүндрүүлэх бүрэлдэхүүнд нэмэлтээр оруулах талаар таны бодол?
5. Израйл улсын Эрүүгийн хуулийн 203-р зүйлийн 1 дэхь хэсгийн Б-д “Бусдыг биеийг нь үнэлүүлэх зорилготойгоор улсын хилээр гарч явахыг ятгасан тохиолдолд 10 жилийн хугацаагаар хорих ял шийтгэхээр” хуульчилсан байдаг бөгөөд Монгол улсын Эрүүгийн хуульд дээрх улсын мөн адилаар эрх зүйн орчинг бүрдүүлэх талаар таны бодол?

**Сэдвийг гүнзгийрүүлэн судлахад ашиглах материал:**

**1. Хууль, эрхийн баримт бичиг**

1. БНМАУ-ын Эрүүгийн хууль.1986 /шинэчлэн найруулсан/
2. Монгол Улсын Эрүүгийн хууль.УБ., 2002
3. “Уголовный кодекс Японии”. Санкт-Петербург. 2002 г
4. Б.Батзориг, Э.Зууннасан. “БНХАУ-ын Эрүүгийн ба Эрүүгийн заргын хууль”. УБ.,2006
5. Улсын Дээд Шүүхийн 2008 оны 03 сарын 26-ны өдрийн 12 тоот тогтоол

**2. Ном, сурх бичиг, гарын авлага**

1. Г.Совд.“БНМАУ-ын Эрүүгийн эрх зүйн курс”.УБ.,1973
2. С.Жанцан.“Монгол улсын Эрүүгийн эрх зүй”. /схемчилсэн тайлбар, зүйлчлэлийн асуудал/. УБ.,2003

3. С.Жанцан.“Монгол улсын Эрүүгийн эрх зүй” /тусгай анги/.УБ., 2003
4. С.Жанцан.“Монгол улсын Эрүүгийн эрх зүй” /өрөнхий тусгай анги/ 2005
5. С.Нарангэрэл.“Монгол улсын Эрүүгийн эрх зүй”/өрөнхий анги/.УБ.,1996, 1999
6. С.Нарангэрэл.“Гэмт хэргийг зүйлчлэх шинжлэх ухааны үндэс”УБ.,1988
7. Г.Совд.“Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар” .УБ., 2003
8. Г.Гантөмөр.“Гэмт хэргийн бүрэлдэхүүний өрөнхий онол”. УБ.,2003
9. Ж.Болдбаатар, З.Төрмандах.“Эрүүгийн эрх зүйн өрөнхий ба тусгай анги”. УБ.,2008
10. З.Төрмандах, С.Гантулга.“Хүн худалдаалах гэмт хэрэг”.УБ.,2008
11. З.Төрмандах, С.Гантулга.“Хүн худалдаалах гэмт хэрэгтэй гүйцэтгэх ажлаар тэмцэх үндэс”.УБ.,2008
12. Эмэгтэйчүүдийг наймаалахын эсрэг эвсэл “ GAATW вэб 2003.11.09-ны өдөр <http://lists.partners-intenet / pipermail - east / 2002 - June / 0002516.html>
13. Trafficking in Persons Report Released by the office to Monitor and Combat trafficking in persons. June 5. 2002.
14. Robyn Emerton Trafficking of woman into Hong Kong for the purpose of Prostitution Preliminari Research findings Centre for Comparative and Public Law.University of Hong Kong.Occasional paper №3, February 2001
15. Advisory Councils of Jurists of the Asia Pacific Forum of National Human Rihts institutions Consideration of the issue of trafficking. Background paper 11-12.Nov. 2002. New Delhi

### **3.1 “ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НОТЛОХ БАРИМТ БА НОТЛОГДВОЛ ЗОХИХ БАДЛУУДЫН ХАМААРАЛТ’ ХИЧЭЭЛИЙГ ЗААХ НЬ:**

**Хичээлийн төлөвлөгөө:**

Д/д	Хичээлийн бүтэц	Хугацаа
1.	Сэдвийн танилцуулга	10 мин
2.	Сэдэвт хамааралтай зарим нэр томъёоны талаар суралцагсадтай ярилцах	20 мин
3.	Онолын мэдлэг олгох /лекц/	30 мин
4.	Асуулт, хариулт /сэдэвтэй холбоотой суралцагсадад ойлгомжгүй асуудлын талаар/	20 мин
5.	Дүгнэлт	10 мин

**Хичээлийг явуулах хэлбэр:**

- Урьдчилан бэлтгэсэн төлөвлөгөөний дагуу сэдвийг ярьж танилцуулах
- Сургалтанд шаардлагатай техник хэрэгслийг ашиглах (компьютер, проектор, дэлгэц гэх мэт)

- Хичээлийн явцад Power point программ дээр бэлтгэсэн Presentation үзүүлэх эсвэл өөр байдлаар бэлтгэсэн материал ашиглах.

**Сэдвийн зорилго:** Хүн худалдаалах гэмт хэргийн нотлох ажиллагаа, нотлох баримтын тухай ойлголт түүний төрөл болон нотлогдвол зохих байдлуудын талаар суралцагсдад тодорхой түвшний ойлголт эзэмшүүлэхэд оршино.

**Сэдвийн агуулга:**

- Нотлох ажиллагаа
- Эрүүгийн хэргийн нотлох баримт түүний шинж, ангилал
- Хүн худалдаалах гэмт хэрэгт нотлогдвол зохих байдлууд

**Сэдэвт хамаарал бүхий зарим нэр томъёоны талаар суралцагчидтай ярилцах:**


- Нотлох ажиллагаа
- Гомдол мэдээлэл
- Эрүүгийн хэрэг үүсгэх үе шатанд хийгдэх нотлох ажиллагаа
- Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд хийгдэх нотлох ажиллагаа
- Нотлох баримт
- Нотолгооны зүйл
- Нотлогдвол зохих нөхцөл байдал



**ГУРАВДУГААР БҮЛЭГ:**  
**ХҮН ХУДАЛДААЛАХ**  
**ГЭМТ ХЭРГИЙГ НОТЛОХ**  
**АЖИЛЛАГАА**

---

**БҮЛЭГ**



- 3.1 *Хүн худалдаалах гэмт хэргийн нотлох баримт ба нотлогдвол зохих байдлуудын харилцан хамаарал*
  - 3.1.1 *Хүн худалдаалах гэмт хэргийн нотлох баримт, төрөл*
  - 3.1.2 *Хүн худалдаалах гэмт хэрэгт нотлогдвол зохих байдлууд, хэмжээ хязгаар*
- 3.2 *Эрүүгийн хэрэг үүсгэх үе шатанд хүн худалдаалах гэмт хэргийн шинж тэмдгийг тогтоох ажиллагаа, онцлог*
  - 3.2.1 *Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авч, шалгах ажиллагаа, анхаарвал зохих асуудлууд*
  - 3.2.2 *Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг шийдвэрлэх ажиллагаа, тогтоогдвол зохих нөхцөл байдлууд*
- 3.3 *Мөрдөн байцаалтын үе шатанд хүн худалдаалах гэмт хэргийг нотлох ажиллагаа, онцлог*
  - 3.3.1 *Хүн худалдаалах гэмт хэргийг нотлох ажиллагааны мөн чанар, үе шат*
  - 3.3.2 *Эрүүгийн байцаан шийтгэх тодорхой ажиллагааны явцад хүн худалдаалах гэмт хэргийн нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх ажиллагаа, онцлог*
- 3.4 *Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа*



**Хяналтын асуулт:**

1. Нотолгоо гэж юуг хэлэх вэ?
2. Нотолгооны зүйл гэж юуг хэлэх вэ
3. Нотлох ажиллагаа гэж юуг хэлэх вэ
4. Нотлох баримт гэж юуг хэлэх вэ?
5. ХХГХ-ийн нотлох баримтын шинжийг нэрлэнэ үү?
6. ХХГХ-ийн нотлох баримтыг эх сурвалжаар нь хэрхэн ангилах вэ?
7. Нотлох баримтыг төрөлжүүлэн ангилсны ач холбогдол?
8. Нотлох баримтуудыг ямар шалгуураар хэрхэн ангилсан байдаг вэ?
9. Сэтгэхүйн нотлох баримт гэж юу вэ? Түүний онцлог
10. Буулгасан нотлох баримт гэж юу вэ?
11. Шууд ба шууд бус нотлох баримтын ялгааг хэлнэ үү?
12. ХХГХ-ийн нотолгооны хэмжээ хязгаарыг тогтооход нөлөөлж буй объектив хүчин зүйлүүдийг нэрлэнэ үү?
13. ХХГХ-ийн нотолгооны хэмжээ хязгаарыг тогтооход нөлөөлж буй субъектив хүчин зүйлүүдийг нэрлэнэ үү?

**Сэдвийг гүнзгийрүүлэн судлахад ашиглах материал:****1. Хууль, эрхийн баримт бичиг**

1. Монгол Улсын Үндсэн хууль.УБ.,1992
2. Монгол Улсын Эрүүгийн хууль.УБ., 2002
3. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль.УБ., 2002
4. Улсын Дээд Шүүхийн 2008 оны 03 сарын 26-ны өдрийн 12 тоот тогтоол
5. Улсын Дээд Шүүхийн тогтоолуудын эмхтгэл.УБ.,2008
6. “Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл”.УБ.,1998
7. Палермогийн протокол.2000 он

**2. Ном, сурх бичиг, гарын авлага, хэвлэлүүд**

1. Б.Батзориг.“Гэмт хэргийн нотолгооны ерөнхий онол” УБ.,2002 он
2. К.Тажебакед, А.Даваадорж “БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй дэх нотлох баримтын онол”УБ.,1989.
3. Б.Галдаа. “Монгол улсын нотолгооны эрх зүйн үндсэн асуудал”УБ.,2001
4. Ж.Бямбаа. Г.Баясгалан.“Монгол улсын ЭБШ эрх зүйн үндсэн асуудлууд”. УБ.,1998
5. Ж.Болдбаатар,Б.Болдбаатар.“Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар борлуулах гэмт хэргийг нотлох ажиллагаа”УБ.,2004.
6. Б.Бат-Эрдэнэ.“Монгол улсын ЭБШ эрх зүй” Ерөнхий анги.УБ.,2000
7. Г.Совд.“БНМАУ-ын Эрүүгийн эрх зүйн курс”.УБ.,1973
8. С.Жанцан.“Монгол улсын Эрүүгийн эрх зүй” /тусгай анги/.УБ., 2003
9. С.Жанцан. “Монгол улсын Эрүүгийн эрх зүй” /өрөнхий, тусгай анги/ 2005

10. Г.Совд.“Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар” .УБ., 2003
11. Г.Гантөмөр.“Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол”. УБ.,2003
12. З.Төрмандах, С.Гантулга.“Хүн худалдаалах гэмт хэрэг”.УБ.,2008
13. З.Төрмандах, С.Гантулга.“Хүн худалдаалах гэмт хэрэгтэй гүйцэтгэх ажлаар тэмцэх үндэс”.УБ.,2008
14. Эмэгтэйчүүдийг наймаалахын эсрэг эвсэл - GAATW вэб 2003.11.09-ны өдөр <http://lists.partners-intenet / pipermail - east / 2002 - June / 0002516.html>
15. Trafficking in Persons Report Released by the office to Monitor and Combat trafficking in persons. June 5. 2002.
16. Robyn Emerton Trafficking of woman into Hong Kong for the purpose of Prostitution Preliminari Research findings Centre for Comparative and Public Law.University of Hong Kong.Occasional paper №3, February 2001
17. Adisory Councils of Jurists of the Asia Pacific Forum of National Human Rihts institutions Consideration of the issue of trafficking. Background paper 11-12.Nov. 2002. New Delhi

**3.2 “ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ҮҮСГЭХ ҮЕ ШАТАНД  
ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН  
ШИНЖ ТЭМДГИЙГ ТОГТООХ АЖИЛЛАГАА”  
ХИЧЭЭЛИЙГ ЗААХ НЬ:**

**Хичээлийн төлөвлөгөө:**

Д/д	Хичээлийн бүтэц	Хугацаа
1.	Сэдвийн танилцуулга	5 мин
2.	Онолын мэдлэг олгох /лекц/	30 мин
3.	Сэдэвт хамаарал бүхий зарим нэр томъёоны талаар суралцагсадтай ярилцах	15 мин
4.	Суралцагсдыг 3 бүлэгт хуваан бодлого бодуулах	20 мин
5.	Бүлэг бүрийн бодлогын хариуг хэлэлцүүлэх	10 мин
6.	Суралцагсдын бодлого бодсон байдалд үнэлгээ өгөх, тайлбар хийх	10 мин

**Хичээлийг явуулах хэлбэр:**

- Урьдчилан бэлтгэсэн төлөвлөгөөний дагуу сэдвийг ярьж танилцуулах
- Сургалтанд шаардлагатай техник хэрэгслийг ашиглах /комьютер,проектор, дэлгэц гэх мэт/
- Хичээлийн явцад Power point программ дээр Presentation үзүүлэх, эсхул өөр байдлаар бэлтгэсэн материал ашиглах

**Сэдвийн зорилго:** Эрүүгийн хэрэг үүсгэх үе шатанд хүн худалдаалах гэмт хэргийн шинж тэмдгийг хэрхэн тогтоох болон энэ үед хийгдэх ажиллагааны онцлогийн талаар онолын ойлголтыг өгөхөд оршино.

**Сэдвийн агуулга:**

1. Хүн худалдаалах гэмт хэргийн талаархи гомдол мэдээллийг хүлээн авч шалгах ажиллагаа, анхаарвал зохих асуудлууд
2. Хүн худалдаалах гэмт хэргийг шалгах хойшлуулшгүй ажиллагаа
3. Хүн худалдаалах гэмт хэргийн талаархи гомдол мэдээллийг шийдвэрлэх ажиллагаа, үндэслэл, журам

***Сэдэвт хамаарал бүхий зарим нэр томъёоны талаар суралцагсадтай ярилцах:***

1. Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх гомдол буюу мэдээлэл
2. Хойшлуулашгүй ажиллагаа
3. Хүн худалдаалах гэмт хэргийн талаархи гомдол мэдээллийг шалгах хуулийн хугацаа
4. Эрүүгийн хэрэг үүсгэх
5. Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргах, татгалзах
6. Гомдол мэдээлийг харьяалалын дагуу шилжүүлэх

***Хяналтын асуулт:***

1. Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх гомдол мэдээлэл ямар хэлбэртэй байж болох вэ?

2. Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийн шалгах хойшлуулашгүй ажиллагааг явуулах субъектүүдийг нэрлэнэ үү?
3. Хүн худалдаалах гэмт хэрэгт ямар ямар төрлийн хойшлуулашгүй ажиллагааг явуулах вэ?
4. Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийг шалгах явцад хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагчаас гүйцэтгэх ажил явуулахаар гүйцэтгэх албандаа даалгавар өгч болох уу?
5. Хүн худалдаалах гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авч шалгаад хэрхэн шийдвэрлэх вэ?
6. Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах үндэслэлийг нэрлэж тайлбарлана уу?
7. Хүн худалдаалах гэмт хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэх үндэслэл нь юу байх вэ?

**Сэдвийг гүнзгийрүүлэн судлахад ашиглах материал:**

**1. Хууль, эрхийн баримт бичиг**

1. Монгол Улсын Үндсэн хууль.УБ.,1992
2. Монгол Улсын Эрүүгийн хууль.УБ., 2002
3. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль.УБ., 2002
4. Улсын Дээд Шүүхийн 2008 оны 03 сарын 26-ны өдрийн 12 тоот тогтоол
5. Улсын Дээд Шүүхийн тогтоолуудын эмхтгэл.УБ.,2008
6. “Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл”.УБ.,1998
7. Палермогийн протокол.2000 он

**2. Ном, сурах бичиг, гарын авлага, хэвлэлүүд**

1. Б.Батзориг.“Гэмт хэргийн нотолгооны ерөнхий онол” УБ.,2002 он
2. К.Тажебакед, А.Даваадорж “БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй дэх нотлох баримтын онол”УБ.,1989.
3. Б.Галдаа. “Монгол улсын нотолгооны эрх зүйн үндсэн асуудал”УБ.,2001
4. Ж.Бямбаа. Г.Баясгалан.“Монгол улсын ЭБШ эрх зүйн үндсэн асуудлууд”. УБ.,1998
5. Ж.Болдбаатар,Б.Болдбаатар.“Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар борлуулах гэмт хэргийг нотлох ажиллагаа”УБ.,2004.
6. Б.Бат-Эрдэнэ.“Монгол улсын ЭБШ эрх зүй” Ерөнхий анги.УБ.,2000
7. Г.Совд.“БНМАУ-ын Эрүүгийн эрх зүйн курс”.УБ.,1973
8. С.Жанцан.“Монгол улсын Эрүүгийн эрх зүй” /тусгай анги/.УБ., 2003
9. С.Жанцан. “Монгол улсын Эрүүгийн эрх зүй” /өрөнхий, тусгай анги/ 2005
10. Г.Совд.“Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар”. УБ., 2003
11. Г.Гантөмөр.“Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол”. УБ.,2003
12. З.Төрмандах, С.Гантулга.“Хүн худалдаалах гэмт хэрэг”.УБ.,2008
13. З.Төрмандах, С.Гантулга.“Хүн худалдаалах гэмт хэрэгтэй гүйцэтгэх ажлаар тэмцэх үндэс”.УБ.,2008
14. Эмэгтэйчүүдийг наймаалахын эсрэг эвсэл - GAATW вэб 2003.11.09-ны өдөр <http://lists.partners-int16net/pipermail-east/2002-June/0002516.html>
15. Trafficking in Persons Report Released by the office to Monitor and Combat

- trafficking in persons. June 5. 2002.
16. Robyn Emerton Trafficking of woman into Hong Kong for the purpose of Prostitution Preliminari Research findings Centre for Comparative and Public Law.University of Hong Kong.Occasional paper №3, February 2001
  17. Adisory Councils of Jurists of the Asia Pacific Forum of National Human Rihts institutions Consideration of the issue of trafficking. Background paper 11-12.Nov. 2002. New Delhi

### **Кейс**

Г 1987 онд төрсөн. Эмэгтэй. Г анх 2006 оны 6 дугаар сард “18-25 насны туранхай, ажил хийх хүсэл эрмэлзэлтэй охидыг өндөр цалинтай ажилд авна. Намхан байж болно” гэсэн зарын дагуу утасдан шалгаруулалтанд оролцохоор болж гэрээсээ гараад сурраггүй болсон. Мөн оны 7 дугаар сард гэр бүлийнхэнтэйгээ холбоо барьсан. Ингэхдээ: “Би сайн байна. Ажил хийж байгаа. Их холоос ярж байна” гээд утсаа тасалсан байна. 2006 оны 10 дугаар сард нэг охин утсаар гэр бүлийнхэнтэй нь холбогдож: “Би Г-ын наиз охин нь байна. Би өөрөө урд нь хууртагдаж яваад ирсэн. Ямар ажил хийж байгааг нь мэдэж байгаа юмуу. Г маш хүнд байдалд байна яаралтай цагдаад мэдэгд. Чизозан гэдэг газар байгаа” гээд утсаа тасалсан байна.

Ингээд гэр бүлийнхэн нь Эрүүгийн цагдаагийн газрын зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тасагт хандаж эрэн сурвалжлах ажлыг эхлүүлсэн байна. 2008 оны 12 дугаар сард Эрээн хот дахь гэмт хэрэгтнүүд гэр бүлийнхэн нь цагдаагийн байгууллагатай хамтарч ажиллаж байгааг нь мэдэж Г-д замын зардлыг нь өгч эх оронд нь буцаасан байна. Ингэхдээ тэд Г-ийн гар дээр ямар ч мөнгө өгөөгүй. Гэмт хэрэгтнүүд Г-д чиний бүх цалинг бид банканд хадгалж байгаа. Зөвхөн чиний бичиг баримтаар авч болох учир чи хүссэн үедээ авч болно. Энэ бүхэн чиний сайн сайхны төлөө гэх мэтээр ярж түүнийг хууран мэхлэсэн байна. Ингээд эх орондоо ирээд удаагүй байтал хэсэг хугацааны дараа гэмт хэрэгтнүүд түүн рүү залгаж “Чи банкнаас цалингаа ирж ав. Учир нь зөвхөн чиний бичиг баримт хэрэгтэй. Чи бичиг баримттайгаа ирэхэд л хангалттай гэх мэтээр ятгасан байна”. Ингээд Г цалингаа авах зорилготой эргэн явсан боловч дахин хууртагдсан болохоо мэдсэн.

Тэд түүнд “Чиний мөнгө бидэнд байгаа. Хэрэв мөнгөө авахыг хүсвэл чи бидэнд хэсэг хугацаанд ажиллаж өг” гэсэн шаардлагыг тавьсан. Гэвч бичиг баримт бусад бүх зүйлсээ тэдэнд хураалгасан Г хэсэг хугацаанд ажиллах болсон. Энэ бүхний эцэст Г тэдний ярж байгаа бүх зүйл худал хуурмаг, ямар ч цалин хөлслгүй ажиллаж байгаагаа мэдсэн.

Г-д түүний үйлчлүүлэгч “н” туслаж сауны газрын эзэнд мөнгө төлж түүнийг авч, Г-ийн визний хугацаа хэтэрсэн байсан учир зохих хэмжээний төлбөрийг нь төлж түүнийг эх оронд нь эргүүлэн авчирсан.

### **Кейс**

Үйлчлүүлэгч Э нь БНХАУ-ын Хэнань мужийн Зэн-Зао хотод массажист мэргэжлээр суралцах зорилготой өөрөөс гадна 6 хүний хамт 2007 оны 9 сард Монголоос явсан. Явахаас өмнө зуучлагч байгууллагатай дадлагагч бэлтгэх гэрээ байгуулсан. Уг гэрээнд суралцах хугацаандаа сарын \$160- \$200 цалинтай, мөн сайн сурч, ажилласан бол өдөр бүр \$20-ын урамшуулалтай. Мөн ажиллах орон

байр, байрлах байр, хувцас хунараар Хятадын тал бүрэн хангана гэсэн гэрээ байгуулсан.

Эхний ээлжинд явж буй хүмүүст урамшуулалтай, замын зардалыг даан авч явсан. Эх орондоо байх үед өгч байсан мэдээлэл нь очсон хойно эрс өөр, суралцаж, ажиллах, амьдрах газар нь халуун ус, саун, массажны үйлчилгээ үзүүлдэг үйлчилгээний газартай нь хамт байсан. Тэдний амьдрах газар нь үйлчилгээний газрынхан нь хонгилд байрлуулсан. Хичээл нь хэзээ орох талаар асуухад болоогүй өөрсдийнхөө байрлаж буй байрыг өдөр болгон цэвэрлэх, мөн үйлчлүүлэгчдийн биеийг угааж, массаж хийж өгөхийг шаардсан. Тэгээд бид эх орондоо иргэлээ дээрх ажлыг бүгдийг нь хийсэн.

Ямар нэгэн цалин хөлс авч байгаагүй. Хөдөлмөр мөлжлөгт өртсөн хохирогчийг эх оронд нь аюулгүйгээр авчрах үйл ажиллагааг Хүйсийн Тэгш Эрхийн Төв нь 2007 оны 10 дугаар сарын 28 нд зохион байгуулж дуусгасан. Уг үйл ажиллагааг Хөх хотын Консул, Замын үүдийн Цагдаагийн газрын туслалцаатайгаар эх оронд нь аюулгүйгээр авчирсан.

***Кейс***

Манай эгч Монголд нэг барилгын компанид ажиллаж байгаад Хятад хүнтэй танилцан гэрлээд Хятадад амьдрахаар явсан. Монголд ээж дээрээ 10 настай хүү, 6 настай охиноо орхиод явсан. Яваад нэг их удаагүй сарын дараа л утсаар яриад, 3 эмэгтэйн хамт барьцаанд байна. Бичиг баримт, мөнгө байхгүй. Очих боломжгүй байна, туслaaч гэж хэлээд одоог хүртэл сураггүй байна. Эгчийгээ олж авчрах хэрэгтэй байна. Одоо яах вэ....

### **Кейс**

Би 25 настай. Нэг найзынхаа зөвлөснөөр гэр бүл зуучлалаар гадаадын иргэнтэй гэрлэхээр шийдсэн. Энэ зуучилж буй байгууллагынхаа нэрийг ч мэдэхгүй. Эзэн нь солонгос хүн байдаг.

Нэг зочид буудалд үйл ажиллагаагаа явуулдаг. Одоо бodoход эрсдэлтэй юм шиг санагдаад гэрлэхээ болихоор шийдсэн. Би нөхөртэйгээ нэг л удаа уулзсан. Гэрлэхээ болих тухайгаа зуучлалын байгууллагадаа хэлэхэд намайг сурдүүлээд нөхөн төлбөр гэж 4000\$ нэхээд байна. Монголд гэр бүлээ батлуулчихсан.....

### **Кейс**

Биднийг Казакстанд 500-1000\$-ын цалинтай барилгын ажил хийх боломжтой орон байр, хувцасаар хангана гээд авч явсан. Очтол нөхцөл байдал өөр байсан. Биднийг тэнд хүлээж авсан хүн цалин өгөхгүйгээр янз бүрийн ажил хийлгэж байсан. Бидний бүх бичиг баримтыг хураан авч өвлийн хүйтэнд төмөр контейнерт хоол ундгүй широнгийн хоригдол шиг байлгаж маш хэрцгийн харьцааж байсан. Ямар нэгэн байдлаар биднийг эсэргүүцэл үзүүлбэл “ална” гэж дарамталдаг байсан. Тухайн улсын хэлийг мэдэхгүй учир тэр газраасаа оргож МУ-ын Элчин Сайдтайгаа уулзах гэж яваад цагдаад баригдсан....

### **Кейс**

Г 21 настай. 2006 оны 12-р сарын эхээр миний танил эгч Солонгост зөөгч хийх хүн байвал авч явна гэж надад хэлсэн. Тунгалаг манай эгчийн ажилладаг кафеын зөөгчийнх нь охиньг Солонгос явуулж өгсөн гээд тэр нь сайн байна, ажлаа хийж байна гэж байнга ярьдаг байсан. Тэгэхээр нь итгээд би гадаад паспорт авсан. Оchoод цалин нь 1000 доллар сайн ажиллавал 1300 доллар авч болно гэсэн. Намайг замын зардлаа өөрөө гаргаарай гэсэн. Би хүнээс 600,000 төгрөг зээлж авч явсан бөгөөд тэр мөнгөөрөө унаа, гоо сайхны бүтээгдэхүүн, хувцас аваарай гэж хэлсэн. Усан онгоцоор Дайлин-аар дамжин Солонгос руу гарна гэж байсан. Виз шаардлагагүй гэсэн. Улаанбаатараас яваад Замын-Үүд Эрээнд очсон.

Оchoод буухад надтай нийлээд 6 охин байсан. Бээжинд нэг буудалд хоноод маргааш нь vogанд суугаад явах замд очоод яг юу хийх вэ? тэгээд хаана байх вэ? Гээд юм асуухад загнаад “Дуугай л яв би та нараар яв л гэж зарчихвал л гэж” очоод юу ч хамаагүй хийнэ гээ биз дээ гэж уурлаж байсан. Бээжинд нэг эрэгтэй хүн тосож аваад хоолонд оруулж, хүнс болон ахуй хэрэглээний зүйл авч өгсөн. Макаод шалган нэвтрүүлэх боомтоор ороход биднийг тусгай машин тосож байсан. Тэнд монгол охид үнэхээр их байдаг юм. Монголын охидын тал хувь нь очсон мэт санагдсан. Хүчээр очсон охид байхад өөрсдөө очсон охид ч байсан...

### **Кейс**

Э. 17 настай. Эмэгтэй. Анх БНХАУ-ын Фен Хуан Сиан Хэй компанитай “1-3 сарын хугацаатай гоо сайхны эмчилгээний сургалтад хамруулан сарын 1200-1500 юаны цалинтай ажил хийлгэх”-ээр гэрээ байгуулан ах дүү, хамаатан садангийн 6 хүмүүсийн хамт БНХАУ-ын Хэ Нань мужийг зорьсон. Хятадын компани бүх зардлын даанаа гэж авч явсан. 2007 оны 09 сарын 02-нд Монголоос явж, 2007 оны 09 сарын 03 нд БНХАУ-ын Хэ-Нан мужийн Джэн Джоу хотод очсон. Очсон даруйд хонгилын наартай өрөөнд оруулж бичиг баримт, утасны карт болон бусад зүйлсийг нь хураан авсан. Тэднийг байнга хянаж, хоол унд өгөлгүй хорионд байлгаж, гомдол гаргасан тохиолдолд цохих, зодох үйлдлийг хийдэг байсан.

**3.3 “МӨРДӨН БАЙЦААЛТЫН ҮЕ ШАТАНД  
ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ  
НОТЛОХ АЖИЛЛАГАА, ОНЦЛОГ”  
ХИЧЭЭЛИЙГ ЗААХ НЬ:**

**Хичээлийн төлөвлөгөө:**

Д/д	Хичээлийн бүтэц	Хугацаа
1.	Сэдвийн танилцуулга	5 мин
2.	Онолын мэдлэг олгох /лекц/	30 мин
3.	Сэдэвт хамаарал бүхий зарим нэр томъёоны талаар суралцагсадтай ярилцах	15 мин
4.	Суралцагсыг 3 бүлэгт хуваан бодлого бодуулах	20 мин
5.	Бүлэг бүрийн бодлогын хариуг хэлэлцүүлэх	10 мин
6.	Суралцагсын бодлого бодсон байдалд үнэлгээ өгөх, тайлбар хийх	10 мин

**Хичээлийг явуулах хэлбэр:**

- Урьдчилан бэлтгэсэн төлөвлөгөөний дагуу сэдвийг ярьж танилцуулах
- Сургалтанд шаардлагатай техник хэрэгслийг ашиглах /компьютер, проектор, дэлгэц гэх мэт/
- Хичээлийн явцад Power point программ дээр Presentation үзүүлэх, эсхүл өөр байдлаар бэлтгэсэн материал ашиглах

**Сэдвийн зорилго:** Хүн худалдаалах гэмт хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагааг явуулах аргачлал болон байцаан шийтгэх тодорхой төрлийн ажиллагааг явуулах онцлогийн талаарх ойлголтыг суралцагсадад эзэмшүүлэхэд оршино.

**Сэдвийн агуулга:**

1. Хүн худалдаалах гэмт хэргийг нотлох ажиллагааны мөн чанар, үе шат
2. ЭБШ тодорхой ажиллагааны явцад хүн худалдаалах гэмт хэргийн нотлох баримтыг цуглуулах бэхжүүлэх ажиллагаа, онцлог
3. Байцаалт, түүнийг явуулах тактик
4. Хохирогчийг байцаах онцлог
5. Хохирогчийг байцаах тактик

6. Хүн худалдаалах гэмт хэрэгт хийгдэх үзлэг, нэгжлэгийн онцлог

***Сэдэвт хамаарал бүхий зарим нэр томъёоны талаар суралцагсадтай ярицах:***

1. Нотлох ажиллагааны үе шат
2. Нотлох баримтыг бэхжүүлэхэд тавигдах шаардлага
3. Нотлох баримтыг үнэлэхэд тавигдах шаардлага
4. Байцаалтын төлөвлөөгөө
5. Байцаах цаг
6. Байцаах газар
7. Сэтгэл зүйн холбоо тогтоох

***Хяналтын асуулт:***

1. Шүүхийн өмнөх шатанд явагдах ХХГХ-ийг нотлох үүрэг бүхий субъектүүдийг нэрлэнэ үү?
2. Мөрдөн байцаалтын шатанд явагдах нотлох ажиллагааны үе шатыг нэрлэнэ үү?
3. ХХГХ-т нотлох баримтыг бэхжүүлэхэд тавигдах шаардлагыг нэрлэнэ үү?
4. ХХГХ-ийн нотлох баримтыг цуглуулах бэхжүүлэх ажиллагааны нийтлэг шинжүүдээс дурьдана уу?
5. Хөтөлсөн асуулт гэж ямар агуулгатай асуултыг хэлэх вэ?
6. Тулгасан асуулт гэж ямар агуулгатай асуултыг хэлэх вэ?
7. Хохирогчид тавих асуултын төрлийг нэрлэж тайлбарлана уу?
8. Үзлэг нэгжлэгийн ажиллагаагаар ХХГХ-ийн нотлох баримтыг цуглуулж бэхжүүлэх ажиллагааны онцлогийг нэрлэнэ үү?

***Сэдвийг гүнзгийрүүлэн судлахад ашиглах материал:***

## **1. Хууль, эрхийн баримт бичиг**

1. Монгол Улсын Үндсэн хууль.УБ.,1992
2. Монгол Улсын Эрүүгийн хууль.УБ., 2002
3. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль.УБ., 2002
4. Улсын Дээд Шүүхийн 2008 оны 03 сарын 26-ны өдрийн 12 тоот тогтоол
5. Улсын Дээд Шүүхийн тогтоолуудын эмхтгэл.УБ.,2008
6. “Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл”.УБ.,1998
7. Палермогийн протокол.2000 он

## **2. Ном, сурх бичиг, гарын авлага, хэвлэлүүд**

1. Б.Батзориг.“Гэмт хэргийн нотолгооны ерөнхий онол” УБ.,2002 он
2. К.Тажебакед, А.Даваадорж “БНМАУ-ын Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй дэх нотлох баримтын онол”УБ.,1989.
3. Б.Галдаа. “Монгол улсын нотолгооны эрх зүйн үндсэн асуудал”УБ.,2001
4. Ж.Бямбаа. Г.Баясгалан.“Монгол улсын ЭБШ эрх зүйн үндсэн асуудлууд”. УБ.,1998
5. Ж.Болдбаатар,Б.Болдбаатар.“Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодисыг хууль бусаар борлуулах гэмт хэргийг нотлох ажиллагаа”УБ.,2004.
6. Б.Бат-Эрдэнэ.“Монгол улсын ЭБШ эрх зүй” Ерөнхий анги.УБ.,2000
7. Г.Совд.“БНМАУ-ын Эрүүгийн эрх зүйн курс”.УБ.,1973
8. С.Жанцан.“Монгол улсын Эрүүгийн эрх зүй” /тусгай анги/.УБ., 2003
9. С.Жанцан. “Монгол улсын Эрүүгийн эрх зүй” /ерөнхий, тусгай анги/ 2005
10. Г.Совд.“Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар” .УБ., 2003
11. Г.Гантемөр.“Гэмт хэргийн бүрэлдэжүүний ерөнхий онол”. УБ.,2003
12. З.Төрмандах, С.Гантулга.“Хүн худалдаалах гэмт хэрэг”.УБ.,2008
13. З.Төрмандах, С.Гантулга.“Хүн худалдаалах гэмт хэрэгтэй гүйцэтгэх ажлаар тэмцэх үндэс”.УБ.,2008
14. Эмэгтэйчүүдийг наймаалахын эсрэг эвсэл - GAATW вэб 2003.11.09-ны өдөр <http://lists.partners-intibnet / pipermail - east / 2002 - June / 0002516.html>
15. Trafficking in Persons Report Released by the office to Monitor and Combat trafficking in persons. June 5. 2002.
16. Robyn Emerton Trafficking of woman into Hong Kong for the purpose of Prostitution Preliminari Research findings Centre for Comparative and Public Law.University of Hong Kong.Occasional paper №3, February 2001
17. Adisory Councils of Jurists of the Asia Pacific Forum of National Human Rihts institutions Consideration of the issue of trafficking. Background paper 11-12.Nov. 2002. New Delhi



